

**Австрали, Монголын Эрдэс баялгийн салбар дах  
хамтын ажиллагааны хөтөлбөр**

**Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний  
үндэсний кодекс (MONVAL) –г нэвтрүүлэхтэй холбоотой  
эрх зүйн орчны судалгаа**

**Улаанбаатар хот  
2020**

## Гарчиг

- **Удиртгал**
- **Нэг. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний олон улсын жишиг, хандлага**
- **Хоёр. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодексийг үнэт цаасны зах зээлд нээлттэй тайлагналын зориулалтаар нэвтрүүлэх боломжийн талаар**
  - 2.1. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний зохицуулалтыг үнэт цаасны зах зээлд нийтлэг зохицуулалт, бүрэн эрхийн хүрээнд нэвтрүүлэх боломжийн талаар;
  - 2.2. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний зохицуулалтыг Хөрөнгийн үнэлгээний болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан “хөрөнгийн үнэлгээ”-ний зохицуулалтад хамаарах байдлаар үнэт цаасны зах зээлд нэвтрүүлэх талаар;
  - 2.3. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний зохицуулалтыг үнэт цаасны зах зээлээс бусад санхүүгийн салбарууд, хувийн хэвшлийн бусад харилцаанд нэвтрүүлэх талаар.
- **Гурав. Байгалийн баялаг, эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн талаар**
  - 3.1. Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалт;
  - 3.2. Газрын хэвлийн тухай хуулийн зохицуулалт;
  - 3.3. Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжууд дах ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээтэй хамаарч болох зарим зохицуулалтын талаар:
    - 3.3.1. Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрх олголтын хүрээнд ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг тогтоох боломжийн талаар;
    - 3.3.2. Аж ахуйн харилцааны явцад ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ тогтоох боломжийн талаар;
    - 3.3.3. Татварын зориулалтаар ашиглаж байгаа үнэлгээний зохицуулалтын талаар;
    - 3.3.4. Нэр томъёоны талаар.
- **Дөрөв. Дүгнэлт, зөвлөмжүүд**
- **Тав. Хавсралтууд**

## Удиртгал

Монгол Улсын Засгийн газар болон Австрали Улсын Засгийн газар хоорондын хоёр талт хамтын ажиллагааны буцалтгүй тусламжийн хүрээнд “Австрали, Монголын Эрдэс баялгийн салбар дах хамтын ажиллагааны хөтөлбөр” (цаашид “**Хөтөлбөр**” гэх)-ийн эхний шат 2015-2019 оны хооронд хэрэгжсэн бол тус Хөтөлбөрийн хоёр дугаар шатыг 2019-2023 оны хооронд илүү өргөн цар хүрээтэйгээр хэрэгжүүлж байна.

Тус Хөтөлбөрийн хоёр дугаар шатны зорилтыг Монгол Улсын ирээдүйн өсөлтөд чухал үүрэгтэй эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад хувь нэмэр оруулахад чиглүүлэн, хөрөнгө оруулалтын орчны тогтвортой, ил тод байдлыг сайжруулахад эрдэс баялгийн салбарын оролцогч талуудын хамтын ажиллагаанд тулгуурлах нь чухал ач холбогдолтой гэсэн үзэл баримтлалтай байна.

Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хамтран ажиллах хүрээнд техник, эдийн засгийн үндэслэлтэй холбоотой чадавхи, мэдлэг, чадварыг дээшлүүлэх нийтлэг ач холбогдол бүхий чиглэлийн хүрээнд Олон улсын ашигт малтмалын үнэлгээний хороо (“International Mineral Valuation Committee” эсхүл хураангуйлснаар “**IMVAL**”)-ноос 2016 онд баталсан загвар кодекстой нийцүүлэн “**Монгол Улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодекс**” (“**МонВал**” буюу англи хэл дээр “Mongolian Mineral Asset Valuation Code”, товчилсноор “**MONVAL**”) -ийг боловсруулах, батлуулах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Хөтөлбөрийн 2019-2020 оны хооронд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу үндсэн 6 ажил гүйцэтгэхээр байгаагийн нэг нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийн хамгаалалтыг нэмэгдүүлэх хүрээнд Монгол Улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекс болох “МонВал” -ийг боловсруулах, батлуулах ажил байна.

Тус кодексийн үндсэн агуулга нь ашигт малтмалын зах зээлийн тухайн үеийн үнэ цэнийг мэргэжлийн шинжээчээр тогтсон арга, аргачлалд тулгуурлан хөрөнгө оруулагчдад маш ойлгомжтой байдлаар бэлтгэн нээлттэй тайлагнах замаар хөрөнгө оруулагчдыг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж, оновчтой шийдвэр гаргах нөхцлийг нь бүрдүүлэх зорилготой байна.

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын “Гурав” дах бүлэгт заасан Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр 3.1.9 дах заалтад “эрдэс баялгийн болон ашигт малтмалын ордын нөөцийг үнэлэх олон улсын стандартад шилжих”-ээр заасан байгаа тул МонВалыг нэвтрүүлэхтэй холбоотой энэхүү ажиллагаа нь төрийн бодлоготой уялдахаар байна.

Хөтөлбөрийн зүгээс дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “**Хороо**” гэх)-той хамтарч ажиллаж байгаа ба Хорооны Ажлын албаны даргын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 330 тоот тушаалаар тус хорооны Үнэт цаасны газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулан МонВалыг боловсруулж, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглээр санал боловсруулахаар ажиллаж байна. Уг ажлын хэсэгт Монголбанк, Уул, уурхай хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газар, “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт болон Хөтөлбөрийн зөвлөх зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл орсон байна.

Хөтөлбөрийн зүгээс Ажлын хэсгийн ажилд дэмжлэг үзүүлэх хүрээнд энэхүү эрх зүйн орчны судалгааг дотоодын эрх зүйн зөвлөхөөр гүйцэтгүүлсэн болно.

Зөвлөхийн зүгээс энэхүү судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэхэд хамтарч ажилласан Хөтөлбөрийн олон улсын зөвлөхөөр ажилласан Австрали Улсын VALMIN Хорооны гишүүн, Австрали Улсын Уул уурхай, Металлурги, Газрын тосны Инженерийн холбооны (AusIMM) гишүүн ноён Стефэн Гемэлл болон Хөтөлбөрийн удирдагч хатагтай Кирстен Ливермооре, дотоодын зөвлөхүүд болох Н.Алгаа, П.Саранчимэг, Б.Гэрэлээ, Ч.Энх-Амгалан, төслийн ажилтан П.Оюунбилэг нарт талархал илэрхийлж байна.

Судалгааны хүрээнд “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ”-ний адил төстэй кодексийг бусад улс орнууд, олон улсын хэмжээнд хэрхэн нэвтрүүлж байгаа, хэрхэн ашиглаж байгаа туршлага, чиг хандлагыг өөрийн орны эрх зүйн орчин, хүчин төгөлдөр үйлчилж байгаа үндэсний хууль тогтоомжийн хүрээнд судалж, холбогдох дүгнэлт, зөвлөмжүүдийг бэлтгэсэн болно.

Судалгааны ажил нь бүтцийн хувьд дараах дөрвөн дэд хэсгээс бүрдэж байна. Үүнд:

1. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний олон улсын жишиг, хандлага;
2. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекс, үнэлгээний тайланг хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд нээлттэй тайлагналын зориулалтаар ашиглах эрх зүйн боломж;
3. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний аргачлал, тайланг ашиглаж болох бусад боломжит хувилбарууд;
4. Дүгнэлт, зөвлөмжүүд.

**Нэг. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний**

## олон улсын жишиг, хандлага

Олон улсын хэмжээнд “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ” нь хөрөнгө оруулагчдад аль болох үндэслэл бүхий, оновчтой шийдвэр гаргах боломж, бололцоог бүрдүүлж өгөх зорилготой байдаг байх ба хөрөнгийн зах зээлд дэх мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгаж хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлж өгдөг байна.

Ингэхдээ, тодорхой ашигт малтмалын нөөцийн тухайн үеийн зах зээлийн үнэ цэнийг мэргэшсэн шинжээчээр тогтоолгодог байх ба уг үнэлгээг ашигт малтмалын үнэлгээний чиглэлээр мэргэшсэн төрийн бус бөгөөд мэргэжлийн байгууллагаас тогтоосон арга аргачлалын дагуу, ёс зүйн өндөр шаардлагын дор хийлгэдэг байна. Ингэж бэлтгэсэн үнэлгээний тайлан нь ямар ч энгийн хэрэглэгч буюу хөрөнгө оруулагчид тухайн ашигт малтмалын нөөцийн үнэ цэнийн талаар хангалттай ойлголт авах боломжийг бүрдүүлж өгдөг байна.

“Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекс”-ийг тухайн улсын хэмжээнд “үндэсний кодекс” байдлаар батлан мөрдүүлэх түүчээ санаачлагыг анх 1995 онд Австрали улс гарган хэрэгжүүлсэн бол уг асуудлаар олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах олон улсын байгууллага нь 2012 онд байгуулагджээ. Тус байгууллагыг Олон Улсын Ашигт Малтмалын Үнэлгээний Хороо (IMVAL) гэх ба уг хорооноос улс үндэстнүүд өөрсдийн онцлогт нийцүүлэн батлан мөрдүүлэх боломжтой “загвар стандарт” буюу “Олон улсын Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний загвар стандарт”-ыг 2016 онд тодорхойлоод байна.

Ашигт малтмалын баялаг, нөөц ихтэй улс орнууд дотроос Австрали, Канад, Африкийн үндэсний кодексууд нь олон улсын хэмжээнд илүү хүлээн зөвшөөрөгдсөн, танигдсан байдалтай байна.

Ойлголтын хувьд “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ” гэх ойлголт нь “ашигт малтмалын нөөц” болон “ашигт малтмалын нөөцийн тайлагнал”, “техник, эдийн засгийн үндэслэл” гэх ойлголтуудаас зарчмын ялгаатай байна. Энгийнээр тайлбарлавал, “ашигт малтмалын нөөцийн тайлагнал” нь газрын хэвлийд байгаа ашигт малтмалын баялаг болон нөөцийн тогтоц, хэмжээ, агууламж гэх зэрэг геологийн шинжлэх ухаанд тулгуурласан судалгаатай холбоотой техникийн нарийвчлан тооцооллыг гаргаж, эрдсийн хуримтлалын үнэмшилд дүгнэлт өгөхөд чиглэдэг үндсэндээ геологийн шинжлэх ухаанд түлхүү тулгуурласан тооцооллын тайлан байдаг байна. Тэгвэл, “техник, эдийн засгийн үндэслэл” нь тодорхой ашигт малтмалын нөөцөд тулгуурлан хэрэгжүүлж болох буюу хэрэгжүүлж байгаа төслийг цаашид хэрэгжүүлэх эсэх буюу үргэлжлүүлэх эсэх гэх мэт төслийг хэрхэн хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргахад зориулагдсан геологи, уул уурхай болон санхүү, эдийн засгийн маш олон тооны нарийвчилсан тооцоолол бүхий судалгаа байдаг байна.

Эдгээр нь тэр бүр хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай байдаг тодорхой цаг үеийн “ашигт малтмалын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ”-г илэрхийлж чаддаггүйгээс хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагчдын дунд тодорхой бус байдал, ойлголтын зөрүү, төөрөгдөл үүсдэг байна.

Иймээс “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ”-ний тайланг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад зориулан хэн боловч ойлголт авах боломжтой байдлаар бэлтгэдэг байх ба уг тайланг нийтэд нээлттэй тайлагналын горимоор ашигладаг байна. Тус үнэлгээнд эрх эзэмшигч компанийн өөрийн хөрөнгө, эд хөрөнгийн үнэлгээг оруулдаггүй байх ба ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг дангаар нь тодорхойлдог байна.

Олон улсын хэмжээнд буюу дэлхийн тэргүүлэх хөрөнгийн зах зээлүүдэд, хөрөнгийн биржүүдэд тодорхой “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекс”-ийг “*хүлээн зөвшөөрсөн*

*хэм хэмжээ буюу өөрийн улсад, өөрийн эрх зүйн орчинд дагаж мөрдөхийг зөвшөөрөх*” зарчмаар нэвтрүүлж байна. Тодруулбал, ашигт малмалын нөөцийн тайлан болон ашигт малмалын хөрөнгийн үнэлгээний тайланг аль алиныг нь хүлээн зөвшөөрсөн улсын мэргэжлийн байгууллагаас баталсан тодорхой үндэсний кодексын дагуу гүйцэтгүүлж байна.

Тухайн кодекс нь хаанаас баталсан байгаагас нь хамаарч хөрөнгийн биржүүдийн зүгээс нэг бол өөр бусад улсын үндэсний кодексийг хүлээн зөвшөөрч хэрэглэх эсхүл өөрийн улсын мэргэжлийн байгууллагаас бэлтгэн баталсан өөрийн улсын үндэсний кодексийг хүлээн зөвшөөрч хэрэглэж байна. Эдгээрийн аль алиныг нь ашиглах байдал ч ажиглагдаж байна.

Гэхдээ, ашигт малтмалын баялаг ихтэй улс орнуудын хувьд өөрийн улсын үндэсний кодекстой байх нь илүү түгээмэл байх тул манай улсын хувьд ч өөрийн улсын үндэсний кодекстой байх нь зүйтэй юм.

Тэгвэл, өөр улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодексыг хүлээн зөвшөөрч хэрэглэж байгаа жишээнүүд тодороос дээр дэрдсанчлан Австрали, Канад болон Өмнөд Африкийн үндэсний кодексуудыг хүлээн зөвшөөрөх нь илүү түгээмэл байна. Тухайлбал, Хонкогийн хөрөнгийн биржийн Үндсэн бүртгэлийн дүрмийн 18 дугаар бүлгээр дээрх гурван улсын үнэлгээний кодексуудыг хүлээн зөвшөөрсөн байна.

Энэ ялдамд, тодорхой кодексийг хөрөнгийн зах зээлд хүлээн зөвшөөрч хэрэглэх явцдаа тухайн хөрөнгийн бирж нь уг кодексийг хэзээ, хэрхэн хэрэглэх талаар нэмэлт зохицуулалт, нарийвчилсан нөхцөл шаардлагыг нэмэлт байдлаар тогтоон мөрдүүлэх боломжтойг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Тухайлбал, “тухайн хэлцэл нь ашигт малтмалын хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой бөгөөд гүйлгээний үнийн дүнгийн дийлэнх хэсгийг ашигт малтмалын хөрөнгө эзэлж байгаа их хэмжээний хэлцэл бол” эсхүл “харилцан хамааралтай бүхий этгээдүүдийн хооронд ашигт малтмалын хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой гүйлгээг хийх бол” гэх мэтээр нийтэд нээлттэй тайлагнах тохиолдлуудыг нарийвчлан тогтоох боломжтой.

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодексийн хөгжлийг тоймолж үзвэл үндэсний стандарт буюу үндэсний кодекстой болох үйл явц 1995 оноос хойш эрчимтэй түгэн дэлгэрсэн байна. Тодруулбал, Австрали Улсын “Австралазийн Уул уурхай, Металлургийн Институт” (“AusIMM”)-ын зүгээс анх 1995 онд “Австралазийн ВалМин кодекс” буюу одоогийн нэршлээр “Техникийн үнэлгээ болон Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний нийтийн нээлттэй тайлангийн Австралазийн кодекс” (VALMIN)-ыг баталж байсан бол түүнээс хойш тус кодексийг 1997, 2005, 2015 онуудад тус бүр шинэчилж байжээ. Өөрөөр хэлбэл, Австрали улс уг асуудлаар анхдагч нь байсан байна.

Харин Канад Улсын тухайд тус улсын Уул уурхай, Металлург, Газрын тосны Институт (CIM)-ээс 2003 онд “Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний стандарт, заавар” (CIMVAL)-ийг баталж байсан байна. Тэгвэл, Өмнөд Африкийн тухайд тус улсын Уул уурхай, Металлургийн Институт болон Геологийн Нийгэмлэгийн хамтарсан SAMCODES стандартын комиссын Ажлын хэсгээс Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний олон нийтэд нээлттэй тайлангийн кодекс (SAMVAL)-ыг 2008 онд боловсруулан мөрдөж эхэлсэн байх ба тус кодексыг 2009 болон 2016 онуудад тус тус шинэчлэн баталж байжээ.

Америкийн Нэгдсэн Улсын тухайд тус улсын Уул уурхай, Металлург, Хайгуулын Нийгэмлэг (SME)-ээс үнэлгээний стандартын анхны хувилбарыг 2016 онд баталсныг тус улсын Олон улсын Ашигт Малтмал Үнэлгээчдийн Институт (ИМА)-ийн зүгээс ашиглан бусад үнэлгээний стандартуудаа шинэчилсэн байна.

Улс орнуудад явагдсан дээрх үйл явдалтай хамт Олон улсын Ашигт Малтмалын Нөөц Тайлагнах Стандартын хороо (CRIRSCO)-ноос баталсан ашигт малтмалын нөөцийн тайлагналын загвартай уялдаа бүхий ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний загварыг боловсруулах зорилго бүхий Олон улсын Ашигт Малтмалын Үнэлгээний Хороо (IMVAL)-г 2012 оны 7-р сард байгуулж байжээ. Тус хороо нь анхны загвар кодексоо 2015 онд баталж байсан бол 2018 онд уг кодексоо дахин сайжруулсан байна.

Олон улсын үнэлгээний стандартын хороо (IVSC)-ны тухайд анх 2001 онд олборлох салбарын хүрээнд үнэлгээчин шинжээчдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулан ажиллуулж, 2005 онд Олборлох салбар дах хөрөнгийн үнэлгээний Заавар дугаар 14 (GN-14)-ийг баталж байжээ. Эдүгээ 2017 онд шинэчлээд байгаа Олон улсын үнэлгээний стандартаар IMVAL-ийн гурав дах загварыг ишилсэн байгаа юм байна.

Манай улсын тухайд одоогоор “МонВал”-ыг болвсруулах санал санаачлага өмнө гарч байсан ч тухайлан ажил хэрэг болж чадаагүй, үндэсний үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хүрээнд Монгол Улсын үндэсний кодекстой байх, түүнийг хүлээн зөвшөөрч ашиглах талаар тухайлсан зохицуулалт тусаагүй байна.

Гэхдээ, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 2018/01 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” (цаашид “**МХБ-ийн Бүртгэлийн журам**” гэх)-ын 13.2.2.8 дах заалтаар “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайлан”-г олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Канадын улсын “Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний журам” /CIMVAL code/, “Үндэсний баримт бичиг” /NI 43-101/, Өмнөд Африкийн “Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайлагналын журам” /SAMVAL code/, Австрали улсын “Ашигт малтмалын хөрөнгийн болон техникийн үнэлгээг олон нийтэд тайлагнах журам” /VALMIN code/ гэсэн стандартуудын дагуу гүйцэтгэж болохоор заасан байгаа нь дэвшилтэй, тодорхой хэмжээнд олон улсын жишигт нийцсэн зохицуулалт болжээ.

Судалгааны хүрээнд МХБ-ийн Бүртгэлийн журамд шаардлагатай засвар, тодруулга, сайжруулалтыг хийж, МонВал-ыг өөр бусад улсын үндэсний үнэлгээний кодексийн нэг адил дагаж мөрдөх талаар Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржийн холбогдох шийдвэрийг гаргуулснаар манай улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг олон улсын жишигтэй нийцүүлэх бүрэн боломжтой байна. Энэ талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

## **Хоёр. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодексийг**

## **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД НЭЭЛТТЭЙ ТАЙЛАГНАЛЫН ЗОРИУЛАЛГААР НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖИЙН ТАЛААР**

Дээр дурдсанчлан олон улсын хөрөнгийн зах зээлүүд ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг нээлттэй тайлагнах шаардлагыг тухайн хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудаас шаардаж байна.

Ингэхдээ, тухайн хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллага болох гол төлөв хөрөнгийн биржийн зүгээс “хүлээн зөвшөөрч дагаж мөрдүүлэх” зарчмаар мэргэжлийн төрийн бус байгууллагаас баталсан кодексын дагуу үнэлгээний тайлангаа гүйцэтгүүлж байхыг шаардаж байна. Үүнийгээ өөрсдийн “үнэт цаасны бүртгэлийн журам”-аараа гол төлөв журамласан байна.

Харин өөрийн улсын үндэсний кодекстой байх уу, эсхүл аль нэг гадаад улсын кодексийг хүлээн зөвшөөрч ашиглах уу гэх асуудлын тухайд байгалийн баялаг, эрдэс баялгийн арвин нөөцтэй улсад тооцогддог, ашигт малтмалын нөөцийн болон ашигт малтмалын үнэлгээний чиглэлээр мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулах боломжтой үндэсний мэргэжилтэн, шинжээчид, төрийн бус байгууллагууд байгуулах бүрэн боломжтой манай улсын тухайд өөрийн улсын үндэсний кодекстой байх бүрэн боломжтой.

Иймд судлаачийн зүгээс үндэсний кодекстой болох хувилбарыг тэргүүн ээлжинд дэмжиж байна.

Аль ч тохиолдолд судлаачийн зүгээс үндэсний кодексийг хэн нэг төрийн байгууллага, хороо, хөрөнгийн биржээс боловсруулж батлах жишиг олон улсын хэмжээнд байхгүй байгааг тэмдэглэн, нийтлэг чиг хандлагын дагуу үндэсний кодексийг мэргэжлийн төрийн бус байгууллагаар боловсруулан батлуулахыг зөвлөж байна.

Улмаар батлагдсан үндэсний кодексийг хөрөнгийн зах зээлд хүлээн зөвшөөрч хэрэглэх нөхцлийг Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжтой юм. Энэ хүрээнд судлаач нь Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, хөрөнгийн зах зээлд мөрдөгдөж байгаа дүрэм журам, Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн бүртгэлийн журам зэргийг судалсан болно.

Судлагааны үр дүнд “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодекс”-ийг үнэт цаасны зах зээлд нэвтрүүлэх асуудлыг хууль тогтоомжид заасан нийтлэг бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх болон “хөрөнгийн үнэлгээ”-ний зохицуулалтын хүрээнд нэвтрүүлэх тохиолдолд одоогийн эрх зүйн орчин, зүйл заалт агуулга ямар байгаа талаар дор дурдсан 2.1 болон 2.2 дах дэд хэсгүүдээр ангилан авч үзсэн болно.

Үүнээс гадна, нэвтрүүлэхээр судалж байгаа MONVAL кодексийн хэрэглээг зөвхөн хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн нээлттэй хувьцаат компаниар хязгаарлалгүйгээр арилжааны банкнаас зээл, төслийн санхүүжилт олгоход ашигладаг болох, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хүрээнд ч банк санхүүгийн байгууллагын шууд оролцоогүй гүйлгээнүүд дээр ашиглаж болдог байх нь макро түвшинд ашигт малтмалын хөрөнгийн талаарх мэдээллийн зөрүүг арилгаж, системийн эрсдлийг бууруулах ач холбогдолтой юм. Энэ талаар 2.3 дах хэсэгт дурдах болно.

**2.1. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний зохицуулалтыг нийтлэг зохицуулалт, бүрэн эрхийн хүрээнд үнэт цаасны зах зээлд нэвтрүүлэх боломжийн талаар**



Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн бирж нар нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай (цаашид “СЗХЭЗБТХ” гэх) болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (цаашид “ҮЦЗЗТХ” гэх)-д заасан үнэт цаасны зах зээлтэй холбоотой нийтлэг бүрэн эрхийнхээ хүрээнд олон улсын жишгийн дагуу хөрөнгийн зах зээлд дагаж мөрдөх дүрэм журмыг тогтоож мөрдүүлж, тодорхой дүрэм журмыг хүлээн зөвшөөрч, хэрэглээг нь зөвшөөрөх, хэрэгжилтийг нь хангах бүрэн боломжтой байна.

#### Санхүүгийн зохицуулах хорооны тухайд

СЗХЭЗБТХ-ийн 1.2 болон 3.1.2 дах заалтаар Хороо нь банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг, үүний дотор Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагааг зохицуулж байна. Тус хуулийн 6.1 дэх хэсэгт зааснаар Хороо нь санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих болон бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох нийтлэг бүрэн эрхтэй байна.

Тэгвэл, ҮЦЗЗТХ-ийн 62.1 дэх хэсэгт зааснаар үнэт цаасны зах зээл дэх төрийн зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь Хороо байх ба мөн хуулийн 62.2 дах хэсэгт зааснаар үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор Хорооноос гаргасан шийдвэрийг үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд биелүүлэх үүрэгтэй байна. Харин санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Сангийн яамны тухайд тус хуулийн 61.1.2 дах заалтын хүрээнд Хороотой хамтран ажиллан, Хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байна.

Хороо нь бүрэн эрхийнхээ хүрээнд ҮЦЗЗТХ-ийн 63.1.2 дах заалтад заасанчлан үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор үнэт цаасны зах зээлд оролцогчийн дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон журам батлан мөрдүүлэх, мөн хуулийн 63.1.4 дэх заалтад заасанчлан үнэт цаасны зах зээлд шударга, үр ашигтай, өрсөлдөөн бүхий, ил тод байдлыг хэвшүүлэхэд шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авах бүрэн эрхтэй байна. Мөн, ҮЦЗЗТХ-ийн 63.1.11 дах заалтын хүрээнд Хороо нь өөрийгөө зохицуулах байгууллага, зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг батлах зөвшөөрөл олгох бүрэн эрхтэй байна.

Үүнээс гадна, ҮЦЗЗТХ-ийн 21.1.4 дэх заалтад зааснаар Хороо нь хөрөнгө оруулагч болон нийтэд хүргэвэл зохих мэдээллийг холбогдох журмын дагуу хүргээгүй болохыг тогтоосон, эсхүл уг нөхцөл байдал үүсч болзошгүй гэж үзвэл үнэт цаас гаргагч болон түүний холбогдох этгээдээс өөрийн тогтоосон журмын дагуу мэдээлэл ирүүлэхийг шаардах эрхтэй байхаар заажээ.

Эдгээрээс дүгнэж үзвэл Хороо нь ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодекс болох МонВал-ыг мэргэжлийн, хараат бус, төрийн бус байгууллагаас баталсан байдлаар нь хэлэлцээд “хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөхийг зөвшөөрөх” тухай шийдвэр гаргах болон тус кодексийг үнэт цаасны зах зээлд хэрэглэхтэй холбоотой нэмэлт шаардлага, горим тогтоох бүрэн боломжтой байна.

Хэдийгээр Монгол Улсын хууль тогтоомжид, ялангуяа, ҮЦЗЗТХ-д тухайлан “хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөхийг зөвшөөрөх”-тэй холбоотой шууд утгаар нь тусгасан томъёолол байхгүй ч олон улсын хөрөнгийн зах зээлийн түгээмэл жишиг болох “бусад улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөхийг зөвшөөрөх” зохицуулалтыг ҮЦЗЗТХ-ийн 18.4 дэх заалтаар “хөрөнгийн биржийн жагсаалт батлах” байдлаар тусгасан байгааг тэмдэглэж байна.

Мөн, үнэт цаасны зах зээлд нийтэд үнэ төлбөргүй хүргэх мэдээлэлтэй холбоотой суурь зохицуулалтыг ҮЦЗЗТХ-иар мөн тодорхойлж өгсөн нь ач холбогдолтой байна. Тодруулбал, ҮЦЗЗТХ-ийн 55.1.4 дэх хэсгийн хүрээнд үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаас гаргагч нь Хороо, хөрөнгийн бирж болон бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон болон үнэт цаас гаргагчийн дүрэм, журамд нийтэд мэдээлэхээр тусгасан мэдээллийг, хоёрдогч зах зээлийн тухайд тус хуулийн 56.1.7 дах заалтын хүрээнд үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан үнэт цаасны үнэ, ханшид нөлөөлж болох бусад нөхцөл байдлын талаар Хороо, хөрөнгийн бирж болон өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд шуурхай мэдээлэх үүрэгтэй байна.

#### Монголын хөрөнгийн биржийн тухайд

Хөрөнгийн бирж нь ҮЦЗЗТХ-ийн 47.2.1 дэх заалтад заасан үнэт цаасны арилжааг зохион байгуулах журам болон мөн хуулийн 47.2.7 дах заалтад заасан үнэт цаасны арилжаа эрхлэхэд шаардлагатай бусад дүрэм, журам, мөн хуулийн 47.2.8 дах заалтад заасан хууль тогтоомж, дотоод журмын дагуу нийтэд мэдээлэхээр заасан бусад мэдээллийн хүрээнд шаардлагатай журмыг батлан, нийтэд мэдээлэл хүргэх боломжтой байна.

ҮЦЗЗТХ-ийн 47.3.3 дах заалтаар Хөрөнгийн биржийн зүгээс нийтэд мэдээлэх мэдээллийн төрлийг тодорхойлсны дотор “хууль тогтоомж, холбогдох журмын дагуу нийтэд мэдээлэхээр заасан бусад мэдээлэл” гэж заасны хүрээнд ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний нээлттэй тайланг нийтэд мэдээлэх мэдээлэлд хамруулан тогтоох байдлаар МонВалыг нэвтрүүлэх бүрэн боломжтой байна.

Хөрөнгийн биржийн бүрэн эрхийн хувьд ч ҮЦЗЗТХ-ийн 49.2 дах хэсэгт заасан үнэт цаасны арилжаа зохих журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих үүргийнхээ хэрэгжилтийг хангах хүрээнд үнэт цаасны арилжаанд оролцогч, үнэт цаас өмчлөгч болон үнэт цаас гаргагчаас шаардлагатай мэдээллийг шаардах эрхийнхээ хүрээнд мэдээлэл авч болохоор байна. Өөрөөр хэлбэл, ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага болон үнэлгээний тайланг үйлдсэн үнэлгээчин зэрэг мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн талууд, бүртгэлтэй хувьцаат компаниас мэдээлэл авах, зохицуулалтаа хэрэгжүүлэх бүрэн боломжтой байна.

Нөгөөтэйгүүр, ҮЦЗЗТХ-ийн 56.2 дах хэсэгт зааснаар хөрөнгийн бирж нь өөрийн бүртгэлд байгаа үнэт цаас, үнэт цаас гаргагчийн талаарх холбогдох мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлж байх үүрэгтэй байна. Тэдгээр мэдээллийн хүрээнд ҮЦЗЗТХ-ийн 56.2.1-д заасан үнэт цаасны ханш, түүнд нөлөөлж болох мэдээлэл болон мөн хуулийн 56.2.8 дах заалтад заасан хууль тогтоомж, Хороо, хөрөнгийн биржээс тогтоосон бусад мэдээлэл хамаарч байна.

Эдгээр зүйл, заалтын хүрээнд Хороо болон хөрөнгийн биржийн зүгээс нийтэд мэдээлэх мэдээллийн хүрээндээ ашигт малтмалын үнэлгээний тайланг хамруулан эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хангах боломжтой байна.

Энэ хүрээндээ ч Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн зүгээс “ашигт малтмалын нөөц” болон “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ”-ний тайлагналтай холбоотой зарим зохицуулалтыг өөрийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-даа хэдийнээ тусгасан байгаа нь тодорхой хэмжээнд дэвшилтэй зүйл болжээ.

Тодруулбал, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 2018/01 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” (цаашид “**МХБ-ийн Бүртгэлийн журам**” гэх)-ын тухайд хувьцааны бүртгэлийн гурван шатны ангилалтай хамааруулан ашигт малтмалын нөөцийн болон ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайлан гүйцэтгүүлэх шаардлага тавьсан байна. Тухайлбал, МХБ-ийн Бүртгэлийн журмын 11.1.6.1, 12.1.5.1, 13.2.2 дах

заалтуудын хүрээнд ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн компаниудын тухайд бүртгэлийн I-III дугаар шатнаас хамааруулан ашигт малтмалын нөөцийн тайланг Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн институтийн мэргэжлийн бүртгэлийн гэрчилгээ бүхий гишүүн эсхүл олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллагын гишүүнчлэлтэй мэргэшсэн мэргэжилтнээр гүйцэтгүүлэх шаардлагыг тавьсан байна.

Ингэхдээ тус журмын 13.2.2.8 дах заалтаар “ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн болон геологи-хайгуулын ажлын үр дүнгийн мэдээлэл”-ийг “Монголын нөөц тайлагнах журам” МНТ /MRC code/ эсхүл Канад улсын “Үндэсний баримт бичиг” /NI 43-101/, Австрали улсын “Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг болон хүдрийн нөөц тайлагнах журам” /JORC code/, Өмнөд Африкийн “Ашигт малтмалын баялаг болон нөөц тайлагнах журам” /SAMREC code/ гэсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тайлагналын стандартуудын аль нэгээр тайлагнаж болохоор заасан байна.

Харин “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайлан”-г “Монголын нөөц тайлагнах журам” МНТ /MRC code/ эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Канадын улсын “Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний журам” /CIMVAL code/, “Үндэсний баримт бичиг” /NI 43-101/, Өмнөд Африкийн “Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайлагналын журам” /SAMVAL code/, Австрали улсын “Ашигт малтмалын хөрөнгийн болон техникийн үнэлгээг олон нийтэд тайлагнах журам” /VALMIN code/ гэсэн стандартуудын аль нэгээр тус тус тайлагнаж болохоор заасан нь нэг талаар дэвшилттэй зохицуулалт болж чадсан ч цаашид засан сайжруулах зарим нэг асуудал байна.

Юуны өмнө, нэгдүгээрт дээрх ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээтэй холбоотой шаардлага нь үнэт цаасны бүртгэлийн нийт гурван шатны бүртгэлээс зөвхөн III дугаар ангилалд бүртгэгдэх “хайгуулын лиценз” бүхий уул уурхайн компаниудад тавигдах шаардлага байх мэтээр журмын 13 дугаар зүйлийн агуулгаас ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны бүртгэлийн эхний хоёр ангилалд бүртгэгдэх боломжтой ашигт малтмал “ашиглах лиценз” бүхий уул уурхайн компанийн тухайд ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайланг гаргах шаардлага тавихгүй мэт ойлгогдож байгаа нь зарчмын алдаатай зохицуулалт болохоор байна. Иймд энэ асуудлыг нятлан нийтлэг байдлаар уул уурхайн бүх компанид тавигдах байдлаар өөрчлөх нь зүйтэй байна.

Товчоор, (1) “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ”-г дан ганц хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр хязгаарлалгүйгээр, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн ашиглах эрх бүхий ашигт малтмалын нөөц/орд буюу ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг мөн тогтоолгодог болгох эсэх, (2) “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ”-г тус журмын 13.2.2.8 дах заалтаар “Монголын нөөц тайлагнах журам” МНТ /MRC code/-р тайлангаж болох мэтээр ташаа зохицуулалт оруулсныг зөвтгөн “МОНВАЛ” кодексийн дагуу гүйцэтгэж байхаар өөрчлөх, (3) “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ”-г хийлгэх нөхцөл шаардлагыг хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд ямар тохиолдолд, горимын дагуу хэрхэн бэлтгэж, хэрхэн нийтэд нээлттэй тайлагнах талаар холбогдох зохицуулалтыг тусгаж, нарийвчилсан зохицуулалттай болгохыг зөвлөж байна.

Мөн, дан ганц үнэт цаасны танилцуулгад ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайланг тусгахаас гадна үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш их хэмжээний хэлцэл хийх, ашигт малтмал хайх эсхүл ашиглах эрх, тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, эсхүл шилжүүлэн авах гэх мэт гүйлгээ хийх тохиолдолд, эсхүл тухайн хэлцлийн дийлэнх хэсэг нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, эрхийн үнэ цэнэ бүрдүүлэх тохиолдолд ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг хийлгэж нээлттэй тайлагнаж байх шаардлагыг тогтоон мөрдүүлж болох юм.

Энэ хүрээнд, Хонконгийн хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлийн журмын 18 дугаар бүлгээр тухайлан “уул уурхайн компаниуд”-тай холбоотой зохицуулалтыг бие даасан тусгай бүлгээр зохицуулсан жишгийг харгалзаж үзэхийг зөвлөж байна.

## **2.2. Ашигт малмалын хөрөнгийн үнэлгээний зохицуулалтыг Хөрөнгийн үнэлгээний болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан “хөрөнгийн үнэлгээ”-ний зохицуулалтад хамаарах байдлаар үнэт цаасны зах зээлд нэвтрүүлэх талаар**

Судалж буй ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг “хөрөнгийн үнэлгээ”-ний нэг хэсэг байна хэмээн үзэж 2010 оноос хойш мөрдөгдөж байгаа Хөрөнгийн үнэлгээний тухай хууль (цаашид “ХҮТХ” гэх)-иар тодорхойлсон суурь зохицуулалт, нөхцөл шаардлагад хамааруулж үзвэл ҮЦЗЗТХ-ийн хүрээнд заасан “хөрөнгийн үнэлгээ” буюу компанийн үндсэн хөрөнгө, эд хөрөнгийн үнэлгээтэй хамааралтай багагүй зүйл заалт, зохицуулалт ашигт малмалын хөрөнгийн үнэлгээг тогтоох, үнэлгээний тайланг ашиглахтай холбоотой харилцаанд нэг адил давхар үйлчлэхээр байна.

### Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн зохицуулалтын талаар

Олон улсын хэмжээнд ашиглаж байгаа “ашигт малтмалын хөрөнгө” буюу “mineral asset” нь ХҮТХ-ийн 3.1.3-г заасан “хөрөнгийн үнэлгээний зүйл” болох *“тодорхой үнэ цэнээр үнэлэгдэх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн өмчлөх эрх”*-д хамаарах эсэх талаар нэг мөр, нэгдсэн ойлголттой болох шаардлага байна.

Одоогоор ХҮТХ-ийн хэрэгжилтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллаж, үнэлгээчний эрхийг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах сонгон шалгаруулалтын үндсэн дээр хувь хүнд олгож байна. Энэ хүрээндээ Сангийн яам нь үнэлгээний дүрэм, журмыг дангаараа эсхүл мэргэжлийн байгууллагатай хамтран баталж мөрдүүлэх, үнэлгээний үйл ажиллагаанд баримтлах нөхцөл, шаардлагыг нарийвчлан тогтоох боломжтой байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа ХҮТХ-ийн үзэл баримтлал нь тусгай зөвшөөрөл бүхий мэргэшсэн үнэлгээчин-хувь хүнээр үнэлгээг гүйцэтгүүлэх зарчимд тулгуурласан байгаа нь ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний олон улсын жишигт нийцэж байна. Агуулгын хувьд ч хөрөнгийн үнэлгээний чиглээр төрийн бус-мэргэжлийн байгууллага байхыг зөвшөөрсөн байгаа зэрэг нь агуулгын хувьд олон улсын жишигтэй зөрчилдөх зүйлгүй байна.

Харин 2019 онд Сангийн яамнаас нийтэд танилцуулаад байгаа “Хөрөнгийн үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга нь зарчмын хувьд хөрөнгийн үнэлгээг хувь үнэлгээчинээр бус “хуулийн этгээд”-ээр гүйцэтгүүлж байх тухай өөрчлөлт оруулсан байх ба “олон нийтийн эрх ашгийг хөндсөн хөрөнгийн үнэлгээ”-г заавал тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээр заасан байх ба уг үнэлгээний төрөлд “ашигт малтмалын ордыг бизнесийн зорилгоор ашиглах үед гүйцэтгэх хөрөнгийн үнэлгээ” хамаарахаар заасан байгаа нь олон улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг хувь үнэлгээчинээр гүйцэтгүүлдэг жишгээс ялгаатай зохицуулалт болохоор байна. Хэрэв хуулийн төслийг олон улсын жишигтэй нийцүүлнэ гэвэл “нээлттэй тайлагнах зориулалтаар бэлтгэх ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн үнэлгээчинээр гүйцэтгүүлж болно” гэх тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаж болох юм.

Шинэчилсэн найруулгын хуулийн төсөл нь ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг зөвхөн “бизнесийн зорилгоор” гэж ангилах нь явцуу зохицуулалт болж болох ба улс орны хэмжээнд хөрөнгийн үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагатай “тухайлан ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээгээр мэргэшсэн төрийн бус байгууллага”-ын статус давхардаж болохоор байх байна.

Эдгээр хоёр саналаас бусдаар Сангийн яамнаас боловсруулаад байга Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодекстийг мэргэжлийн байгууллагаар бэлтгүүлэн батлуулж, улмаар үнэт цаасны зах зээлд хүлээн зөвшөөрч ашигладаг болгоход саад бэрхшээл учруулах, хязгаарлах болон хориглох зүйл заалт байхгүй байна гэж үзсэн болно.

#### Үнэт цаасны зах зээлийн тухай хууль дах хөрөнгийн үнэлгээтэй холбоотой зохицуулалтын талаар

ҮЦЗЗТХ-ийн дагуу “хөрөнгийн үнэлгээ”-ний ажил үйлчилгээ нь Хороонд бүртгүүлсний үндсэн дээр эрхлэх “зохицуулалттай үйл ажиллагаа”-нд хамаарч байна. Өөрөөр хэлбэл, Хороо нь ҮЦЗЗТХ-ийн 63.1.6 дах заалтад зааснаар хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээсээ хасах бүрэн эрхтэй байна. Энд хөрөнгийн үнэлгээг хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх агуулга байгааг анхаарах нь зүйтэй болов уу.

Түүнчлэн, ҮЦЗЗТХ-ийн 24.1.16 дах заалтаар хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа нь зохицуулалттай үйл ажиллагаанд хамаарахаар мөн заасан бол тус хуулийн 33.2.2 дах хэсэгт хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь гэрээний үндсэн дээр байнга ажиллах, хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий тогтоосон тооны үнэлгээчинтэй байх шаардлагыг хангасан тохиолдолд Хорооны бүртгэлдээ бүртгэхээр заажээ. ҮЦЗЗТХ-ийн энэхүү зохицуулалт нь нэг талаас тусгай зөвшөөрөл авах шаардлагыг Хөрөнгийн тухай хуулиас гадна давхар тавиагүй байгаа нь хүн суртлыг бууруулж байгаа давуу талтай байж болно.

Нөгөөтэйгүүр, ҮЦЗЗТХ-ийн 33.3 дах хэсгээр хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааны тухайд тухайлан тавих нөхцөл, шаардлагыг харьяалах өөрийгөө зохицуулах байгууллага буюу хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын саналыг харгалзан Хороо тогтоохоор заасан байна.

ҮЦЗЗТХ-д заасан “хөрөнгийн үнэлгээ”-тэй холбоотой бусад зохицуулалтыг тоймолбол, хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий байгууллагад тавигдах шаардлага, бүртгэлд хамрагдсан байх, хөрөнгийн үнэлгээг зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх, нийтэд үнэт цаасыг нээлттэй санал болгон худалдах үед үнэт цаасны танилцуулгад хөрөнгийн үнэлгээний тайланг заавал хавсаргах шаардлагын хүрээнд ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөлтэй бол тэдгээрийн дагуу хайх, ашиглах эрх бүхий ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайланг хавсаргах шаардлага үйлчилж болохоор байна. Энэ хүрээнд уг үнэлгээ нь сүүлийн 1 жилийн дотор хийгдсэн байх шаардлагатай ба үнэт цаасны танилцуулгад гүйцэтгэсэн шинжээч, үнэлээчийн талаар мэдээлэл өгөх, хөрөнгийн үнэлгээний арга аргачлал, журмыг Хороо нь хөрөнгийн үнэлгээний эрх бүхий мэргэжлийн байгууллагын саналыг харгалзан тогтоох гэх мэт зохицуулалтууд байна.

Түүнчлэн, үнэт цаасыг нийтэд санал болгох анхдагч болон хоёрдогч зах зээлийн харилцааны хүрээнд шаардагдах бичиг баримтын бүрэлдэхүүнд “хөрөнгийн үнэлгээ”-ний нийтлэг шаардлагыг тусгасан байх ба ҮЦЗЗТХ-ийн 10.5.16 дах хэсэгт сүүлийн нэг жилээс дээшгүй хугацааны дотор хийлгэсэн хөрөнгийн үнэлгээний тайланг үнэт цаасны танилцуулгад тусгасан байх шаардлагыг тусгасан байна.

Үүнээс гадна, үнэлгээг гүйцэтгэх этгээдэд тавигдах нийтлэг шаардлага, тайлангийн нийтлэг агуулгыг ч мөн тодорхойлсон байна. Тухайлбал, ҮЦЗЗТХ-ийн 10.8 дах хэсэгт зааснаар “үнэт цаасны танилцуулга”-д тусгасан мэдээлэлд хөндлөнгийн шинжээч, мэргэжилтний үнэлэлт, дүгнэлт багтсан бол уг баримтын талаар дор дурдсан мэдээлэл, тодорхойлолтыг тухайн танилцуулгад хавсаргахаар заасан байна. Үүнд:

1. тухайн дүгнэлтийг гаргах эрхтэй болохыг нотлох баримт;
2. тухайн дүгнэлтийг гүйцэтгэсэн шинжээчийн нэр, хаяг, туршлага;
3. тухайн дүгнэлтийг сонирхлын зөрчилгүйгээр, зохих журмын дагуу гүйцэтгэсэн тухай шинжээчийн баталгаа;
4. тухайн дүгнэлтийг үнэт цаасны танилцуулгын хамт нийтийн хүртээл болгоход татгалзах зүйлгүй талаарх дүгнэлт.

Харин агуулгын хувьд ҮЦЗЗТХ-ийн 10.9 дэх хэсэгт “шинжээчийн дүгнэлт” нь дор дурдсан агуулгатай байхаар заажээ. Үүнд:

1. шинжээчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, дүгнэлт хийх эрх бүхий болохыг нотлох мэдээлэл;
2. дүгнэлт гаргуулах хүсэлт гаргасан захиалагчийн талаарх мэдээлэл;
3. шинжилгээ хийсэн хугацаа, давтамж, он, сар, өдөр;
4. захиалагчийн даалгавар;
5. шинжилгээнд ашигласан аргачлал, шинжилгээний хамарсан хүрээ, танилцсан баримт бичиг, хамрагдаагүй асуудал;
6. шинжээчийн дүгнэлтийн агуулга;
7. шинжилгээг зохих журмын дагуу гүйцэтгэсэн болон сонирхлын зөрчилгүй болох тухай шинжээчийн баталгаа;
8. шинжээчийн гарын үсэг, тэмдэг;
9. Хороо болон хөрөнгийн биржээс тогтоосон бусад зүйл.

Энд тэмдэглэх зүйл бол шинжээчийн дүгнэлтийн агуулгад Хороо болон Хөрөнгийн биржийн зүгээс нэмэлт шаардлага тавьж болохоор заасан нь чухал юм. Өөрөөр хэлбэл, хуульд заасан дээрх шаардлагаас гадна, тухайн үнэлгээний зүйлтэй холбоотой өөр бусад онцлог нөхцөл, шаардлагыг Хороо болон хөрөнгийн биржээс тус бүр тогтоож болохоор байна.

Эцэст нь ҮЦЗЗТХ-ийн 10.11 дэх хэсэгт зааснаар Хороонд ирүүлэх үнэт цаас гаргах хүсэлт, үнэт цаасны танилцуулга, түүний хуулбарт үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч гарын үсэг зурахаас гадна хавсаргасан дүгнэлт гаргасан хуульч, санхүүгийн шалгалт хийсэн аудитор болон бусад шаардлагатай хөндлөнгийн шинжээч гарын үсэг зурж баталгаажуулахаар заасан байна.

Эдгээрээс дүгнэж үзвэл, аль ч тохиолдолд “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ”-г Хороо болон хөрөнгийн биржийн зүгээс дангаараа, эсхүл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран Монгол Улсын үнэт цаасны зах зээлд нэвтрүүлэх бүрэн боломжтой байна.

Хэрэв, “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ” нь ХҮТХ-ийн зохицуулалтад хамаарна гэж үзвэл ХҮТХ, ҮЦЗЗТХ-иар илүү нарийвчилсан нөхцөл, шаардлага, зохицуулалтууд үйлчилэхээр байх ба энэ хүрээнд Сангийн яам болон хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах хэрэгцээ, шаардлага илүү байхаар байна.

### **2.3. Ашигт малмалын хөрөнгийн үнэлгээний зохицуулалтыг үнэт цаасны зах зээлээс бусад санхүүгийн салбарууд, хувийн хэвшлийн бусад харилцаанд нэвтрүүлэх талаар**

Монгол Улсын санхүүгийн зах зээл нь банкны систем давамгайлсан бүтэцтэй байгаа, хөрөнгийн зах зээлийн хөгжил хангалттай түвшинд хүрээгүй байгаа зэрэг өнөөгийн нөхцөл байдал,

онцлогтой уялдуулж ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний хэрэглээг дан ганц хөрөнгийн зах зээлээр хязгаарлахгүй байхыг зөвлөж байна.

Нэгэнт, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалан санхүүжилт авахыг зөвшөөрсөн байгаа тул юуны өмнө банкны салбарт МонВалыг ашигладаг байх явдлыг дэмжих нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, арилжааны банкнаас уул уурхайн төсөл хөтөлбөрийн зориулалтаар ихээхэн хэмжээний бизнесийн зээл, төслийн санхүүжилт олгохдоо барьцаа хөрөнгө, эрхийн үнэ цэнийг аль болох бодитой тогтоосны үндсэн дээр зээл олгох шийдвэр, нөхцөлийг тодорхойлж байх нь эрсдлийг бууруулахад ихээхэн ач холбогдолтой. Ялангуяа, үнэлгээг банк өөрөө биш, хөндлөнгийн бөгөөд мэргэжлийн үнэлгээчинээр гүйцэтгүүлж байх нь зээлийн эрсдлийн үнэлгээг аль болох бодитой хийх, тэр хэрээр муу болон чанаргүй зээлийн хэмжээг нэмэхгүй байх буюу банкны салбарын тогтвортой байдлыг хангаж ажиллахад чухал ач холбогдолтой.

Энэ хүрээнд Төв банкны тухай хуулийн 27<sup>2</sup> дугаар зүйлийн хүрээнд тус асуудлын талаар Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлаас бүрдсэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, банкны салбарын хүрээнд уул уурхайн компаниудад зээл, санхүүжилт олгоход МонВал-ыг ашигладаг болгох талаар бодлогын болон зөвлөмж, арга зүйн арга хэмжээ авч хэрэгжүүлэх бүрэн боломжтой байна.

Үүнээс гадна, МонВал-ыг уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн хуулийн этгээдийн хүрээнд ч мөн ашиглах боломжтой бөгөөд тус үнэлгээний кодексийг төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн үнэлгээг тогтоох, үйл ажиллагааг нь өргөжүүлэх хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах гэх мэт тохиолдлуудад хаалттай хүрээнд ч гэсэн ашиглах боломжтой.

Нөгөөтэйгүүр, заавал төрийн өмчит эсхүл хөрөнгийн биржид бүртгэлтэй гэж ялгалгүйгээр, тухайн компанийн хөрөнгө оруулагчид, харилцагчид хоорондоо тохиролцсон тохиолдолд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий аливаа хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тухайд ч мөн ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг хөндлөнгийн мэргэжлийн шинжээч-үнэлгээчнээр тогтоолгох бүрэн боломжтой юм. Магадгүй энэ тохиолдолд үнэлгээний үр дүнг заавал нээлттэй тайлагнахыг шаардахгүй.

Дүгнэж үзвэл, энэхүү үнэлгээний кодекс нь системийн эрсдлээс сэргийлэх ач холбогдолтой байна. Тиймээс, уг асуудлаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс арга хэмжээ авч хэрэгжүүлэх бүрэн боломжтой байна.

Өөрөөр хэлбэл, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны Дарга, Сангийн Сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захиралын хамтарсан тушаалаар 2018 онд баталсан “Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажиллах дүрэм”-ийн 3 дугаар зүйлд заасан эрх, үүргийнхээ хүрээнд санхүүгийн асуудлаар зөвлөмж, дүгнэлт, шийдвэр гарган УИХ, олон нийтэд мэдээлэх, тус зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааг уялдуулах, гадаад орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, сайн туршлагыг судалж, өөрийн орны санхүүгийн салбарт нэтврүүлэх санал боловсруулж шийдвэрлэх зэрэг арга хэмжээ авах бүрэн боломжтой байна.

**Гурав. Байгалийн баялаг, эрдэс баялгийн салбарын  
хууль тогтоомжийн талаар**

Эрх зүйн зохицуулалтын хувьд “байгалийн баялаг”-ийг газрын хэвлий дэх, эсхүл газрын гадарга дах, эсхүл нөхөн сэргээгдэх, эсхүл үл нөхөн сэргээгдэх, эсхүл ашигт малтмал, ургамал, ан амьтан ба бусад гэх мэтээр ангилан тус бүрийн онцлогоос нь хамааруулж тэдгээрийг ашиглахтай холбоотой харилцааг өөр өөр хууль тогтоомжоор харилцан ялгаатай байдлаар зохицуулж байна.



Энэ дотроос “газрын хэвлий, түүний баялаг”-ийг буюу эрдэс баялгийг ашиглахтай холбоотой харилцааг Үндсэн хууль, Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Цөмийн энергийн тухай хуулиудаар голлон зохицуулж байна. Судлаачийн үзэж байгаагаар өнөөгийн Монгол Улсын эрдэс баялгийн хууль тогтоомжуудаар нэвтрүүлэхээр яригдаж буй МонВал буюу “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодекс”-ыг олон улсад хэвшсэн утга, агуулгаар нь хэрхэн ашиглах, үнэлгээг хэрхэн гүйцэтгэх болон үнэлгээний үр дүн болох тайланг хэрхэн ашиглах талаар зохицуулсан зүйл хуулиудад байхгүй байна.

Гэхдээ, МонВал кодексоос өөр арга, аргачлалаар, өөр бусад зорилго, зориулалтын тулд ашигт малтмалын үнэлгээг тодорхой хэмжээнд тогтоож байна гэж үзэж болох тохиолдлууд байна. Тухайлбал, газрын хэвлий дэх эрдэс баялгийн үнэлгээг шууд бусаар “тусгай зөвшөөрлийн үнэлгээ”-ний хувиар тогтоон, татвар ногдуулалтын зорилгоор ашиглах зохицуулалт татварын хуулиудад байна.

Нөгөөтэйгүүр, тодорхой ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эрх зүйн байдалтай холбоотой тодорхой тохиолдолд, тухайлбал, зарим талбайг шилжүүлэх, үүнтэй холбоотой нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, тусгай зөвшөөрлийг барьцаалах, эсхүл бусдад шилжүүлэх, эсхүл тодорхой ордыг хамтран ашиглах гэрээ байгуулах гэх мэт харилцааны хүрээнд ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг хөндлөнгийн мэргэшсэн шинжээч-үнэлгээчнээр тогтоолгон ашиглах эрх зүйн боломж нээлттэй буюу хориглосон зүйлгүй байна.

Иймд энэхүү бүлгийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалтаас эхлэн эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж дах эрдэс баялагийн үнэ цэнийг тодорхойлох, эсхүл ашиглах хэрэгцээ гарах боломжтой буюу магадлал бүхий зохицуулалтын талаар тоймлон авч үзэх болно.

### **3.1. Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалт**

Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж, мөн зүйлийн 2 дах хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын Их хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр дээр дурдсан зургадугаар зүйлийн 2 дах хэсэгт дараах өөрчлөлтийг оруулаад байгаа ба уг өөрчлөлтийг 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 12 цагаас эхлэн дагаж мөрдөх юм. Үүнд:

*“Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан **төрийн нийтийн өмч** мөн.*

*Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.*

*Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.*

*Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.”*

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2 дах хэсгийн 4 дэх заалтын дагуу Засгийн газар нь төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийнхээ дагуу “хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах” үндсэн бүрэн эрхтэй байна.

Эдгээрээс авч үзвэл байгалийн баялаг нь төрийн нийтийн өмч байх ба стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх Үндсэн хуульд заасан нөхцөл, шаардлагын хүрээнд ойрын ирээдүйд зарим хууль тогтоомжид өөрчлөлт орохоор байна.

### **3.2. Газрын хэвлийн тухай хуулийн зохицуулалт**

1988 онд батлагдсан Газрын хэвлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар газрын хэвлий нь төрийн өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө мөн.” гэж, мөн зүйлийн 2 дах хэсэгт “Газрын хэвлийг зөвхөн ашиглуулахаар олгоно. Газрын хэвлийг төр өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр зөрчихийг хориглоно.” гэж заасан. Түүнчлэн тус хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “**газрын хэвлий**” гэдгийг “хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /**бүх төрлийн чөлүүлаг, ашигт малтмал болон геологийн бусад биет**, түүнчлэн барилга байгууламж/-ийг” хамааруулан өргөн хүрээнд ойлгохоор тодорхойлсон байгаа.

Газрын хэвлийн ашиглалтын тухайд Газрын хэвлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Газрын хэвлийг Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэд ашиглаж болно.” гэж, мөн зүйлийн 2 дах хэсэгт “Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд газрын хэвлийг гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашиглуулж болно.” гэж тус тус заасан байдаг. Тус хуульд зааснаар газрын хэвлийг (1) геологийн судалгаа хийх, (2) ашигт малтмал олборлох, (3) ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах, (4) аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах зориулалтаар ашиглаж болохоор заасан.

Гэхдээ “ашигт малтмал”-ын тухайд Газрын хэвлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дах хэсэгт “Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна.” гэж тухайлан заасантай холбоотой газрын хэвлий дэх ашигт малтмалыг зөвхөн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох замаар хайж, ашиглаж болохоор байгаа.

Хэдийгээр Газрын тухай хуулийн 45 дугаар зүйлд ашигт малтмалын нөөц, орд, илрэлийг улсын нэгдсэн тоо бүртгэлд заавал бүртгэхээр зааж, мөн хуулийн 46 дугаар зүйлд ашигт малтмалын ордын улсын дансыг үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийн нөөцийн хэмжээ, чанар, ордыг ашиглах уул-техник, гидрогеологийн болон бусад нөхцөл, түүний геологи-эдийн засгийн үнэлгээг орд тус бүрээр, ашигт малтмалыг илрэл бүрээр нь тусган харуулсан байдлаар зохиохоор заасан байгаа ч ашигт малтмалын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг мэргэшсэн үнэлгээчнээр, тухайлсан кодексын дагуу гүйцэтгэх тухай агуулга хуульд байхгүй байна.

### **3.3. Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжууд дах ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээтэй хамаарч болох зарим зохицуулалтын талаар**

Энэ хэсэгт Ашигт малтмалын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Цөмийн энергийн тухай болон татварын хуулиуд дах ашигт малтмалын тусгай

зөвшөөрлийн үнэлгээтэй хамааралтай хэсгийн талаар дурдана. Юуны өмнө эдгээр нарийвчилсан хуулиудад “ашигт малмалын хөрөнгийн үнэлгээ”-тэй холбоотой тухайлсан зохицуулалт байхгүй байна.

Эрдэс баялгийг салбарын хууль тогтоомжуудад “*байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч байх ба төр нь уг төрийн өмчийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрх олгох замаар ашиглуулах*” суурь зарчим үйлчилж байна.

Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 5.1 дэх хэсэгт “*Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн*” гэж, мөн хуулийн 5.2 дах заалтад “*Төр өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу ашигт малтмал эрх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй*” гэж заасан байна.

Эндээс дүгнэж үзвэл, төр нь өмчлөгчийн хувиар байгалийн байдлаараа оршиж байгаа өөрийн өмчлөл дэх ашигт малтмалын хөрөнгийг “төрийн өмч” болохын хувьд үнэлэх, үнэлгээ тогтоох эрх зүйн боломж нээлттэй байна гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн хүрээнд тооллого, үнэлгээ, бүртгэлийн ажиллагаа явуулж болно. Гэхдээ өнөөгийн байдлаар тухайлан ашигт малмалын хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн хүрээнд тооллого, үнэлгээ, бүртгэлийн ажиллагаанд хамруулж байгаа эсэх нь тодорхойгүй, төрийн өмчлөл дэх ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг хэрхэн гүйцэтгэх талаар нарийвчлан тодорхойлсон дүрэм, журам байхгүй байна.

Гэхдээ, тодорхой хэмжээнд ашигт малтмалын хөрөнгийн эсхүл ордын, эсхүл нөөцийн, эсхүл тусгай зөвшөөрлийн үнэлгээ тогтоох, эсхүл өөр бусад нөхөн төлбөр, төлбөрийн хэмжээг тогтоох хүрээнд ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг ашиглах боломжтой тохиолдууд байгааг энэхүү бүлэгт тоймлон тэмдэглэж, тэдгээр зохицуулалтын мөн чанар, агуулгын талаар тусгасан болно.

Энэ ялдамд, судлаач Д.Даваасамбуу нарын зүгээс (1) улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордын хайгуулын зардлыг олборлолтын явцад гэрээ байгуулсан улсын төсөвт буцаан төлөх Ашигт малмалын тухай хуулийн зохицуулалт<sup>1</sup>, (2) хайгуулын зардлыг “хайгуул, үнэлгээний хөрөнгө” гэсэн утгатай дансанд хуримтлуулан бүртгэж байгаа Сангийн сайдын 2011 оны тушаал,<sup>2</sup> (3) “Ашигт малмалын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, тусгай зөвшөөрөл шилжүүлсний орлогод татвар ногдуулах аргачлал” батлах тухай Сангийн

---

<sup>1</sup> Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн хувьд улсын төсвийн хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр хайгуулын ажил хийж, нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газраас олборлолт явуулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуулын ажилд улсын төсвөөс гаргасан зардлыг олборлолт явуулж эхэлсэн хугацаанаас эхлэн гэрээний үндсэн дээр улсын төсөвт буцааж нөхөн төлөхөөр заасан байдаг. Өөрөөр хэлбэл, нөөцийг нь тогтоосон ордыг төр ашиглуулахдаа нөөцийг тогтоохтой холбоотой гарсан ашигт малтмалын ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, хайгуулын бүх шатны ажилд улсын төсвөөс гаргасан зардлыг нөхөн төлүүлэх зохицуулалттай байгаа.

<sup>2</sup> 2019 онд УИХ-аас шинэчлэн баталсан ААНОАТ-ын 7.13-т ашигт малтмал болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч, Газрын тосны тухай хуульд заасан гэрээлэгч аж ахуйн нэгж нь хайгуулын зардал, тусгай зөвшөөрлийн төлбөр, тусгай зөвшөөрөл эзэмших болон худалдах, шилжүүлэн авахтай холбогдон гарсан зардлыг хуримтлуулан “хайгуул үнэлгээний хөрөнгө”-өөр бүртгэж, уурхай болон талбайн ашиглалтын хугацаанд элэгдэл, хорогдол байгуулахаар, мөн хуулийн 17.14-т Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8-д заасан тусгай сан, Газрын тосны тухай хуулийн 11.2.9-д заасан данс, Цөмийн энергийн тухай хуулийн 28.9-д заасан санд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг энэ хуулийн 17.13-т заасан хайгуул үнэлгээний хөрөнгөд тооцохоор тус тус заасан байгаа. Өөрөөр хэлбэл, Сангийн сайдын 2011 оны тушаалаар тодорхойлж байсан зарчим хэвээр байна.

сайдьг 2017 оны 380 дугаар тушаал зэргийг ашигт малмалын хөрөнгийн үнэлгээг тогтоох чиглэлээр батлагдсан зохицуулалтууд байна гэж үзсэн байгааг тэмдэглэж байна.<sup>3</sup> Гэвч, энэхүү нягтлан бодох бүртгэлийн журам, хайгуулын зардлыг нөхөн төлөх зохицуулалт болон татварын зорилгоор ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн буюу эрхийн үнэлгээг тогтоохтой холбоотой зохицуулалт нь олон улсын хэмжээнд ашиглагдаж байгаа “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекс”-уудтай ямар ч хамааралгүй болохыг анхаарах хэрэгтэй ба уг агуулгаар дурдсан гурван зохицуулалтыг ашигт малмалын хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тогтоож байна гэж үзэх боломжгүй юм.

Нэгэнт эрдэс баялгийн хууль тогтоомжид “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ”-тэй холбоотой зохицуулалт байхгүй тул нийтлэг зохицуулалтын хүрээнд “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ”-г тогтоолгон ашиглах боломжийн талаар хийсэн судалгааны үр дүнг энэ хэсэгт тоймлон тусгасан болно. Ингэхдээ, “эрх олгох” хүрээний болон эрх олголттой холбоогүй аж ахуйн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааны хүрээний гэх хоёр бүлэгт ангилан авч үзлээ. Үүнд:

### **3.3.1. Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрх олголтын хүрээнд ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ тогтоох боломжийн талаар**

#### Тусгай зөвшөөрөл олгох хүрээнд

Эрдэс баялгийн салбарын үндсэн хууль тогтоомжуудыг нягталбал, ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах эрхийг тусгай зөвшөөрөл олгох замаар олгож байна. Өөрөөр хэлбэл, төр нь өөрийн өмчлөл дэх ашигт малтмалыг ашиглах эрхийг өөрийн давуу эрхийн хүрээнд өөрийн тодорхойлсон арга, аргачлалын дагуу шаардлага хангасан хуулийн этгээд (бичил уурхай эрхлэгчдийн тухайд нөхөрлөлд)-д олгож байна.

Зарим судлаачдын зүгээс төр нь энэхүү эрхийг олгохдоо ашигт малмалын хөрөнгийн үнэлгээг тогтоон, ашигт малмалын хөрөнгийг ашиглах эрхийг төлбөртэйгөөр олгож байх байр суурийг илэрхийлсэн байдаг. Тухайлбал, Д.Даваасамбуу нар “... ашигт малтмалын баялаг нь төрийн өмч мөн гэж заасан ч тодорхой үнээр (яг хэдэн төгрөг гэж) үнэлэхгүй байгаа учир түүнийг дотоод болон гадаадын иргэн, аж ахуйн нэгжид эзэмшүүлэхдээ огт үнэгүй шилжүүлж байгаа нь асар их хэмээний мөнгөн хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлэх боломжоо алдсаар байна.” гэж үзсэн байдаг.<sup>4</sup>

Судлаачийн зүгээс зарчмын хувьд нэгэнт “ашигт малмалын нөөц ашигласны төлбөр”-ийг авч байгаа бол, дээр нь төрөөс гүйцэтгэсэн эрэл, хайгуулын зардлыг нөхөн төлүүлж байгаа бол тусгай зөвшөөрлийг олгохдоо холбогдох “ашигт малмалын хөрөнгийн үнэлгээ”-нд тулгуурлан төлбөр авах нь агуулгаараа давхар төлбөр авах нөхцлийг бүрдүүлэх тул сайтар нягтлах шаардлагатай гэж үзэж байна. Магадгүй, тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны хэлбэрээр, сонирхогч талуудын хооронд үнэ хаялцуулах байдлаар тусгай зөвшөөрлийг олгодог болбол эрх олгох ашигт малтмалын хөрөнгийн талаар үнэн зөв мэдээлэл өгөх шаардлагын хүрээнд үнэлгээ хийлгэдэг болох нь илүү ач холбогдолтой болж болох юм.

Үүнээс гадна, дараах тохиолдолд шууд бус байдлаар ашигт малмалын хөрөнгийн үнэлгээг тогтоолгон ашиглах шаардлага үүсч болох юм. Тухайлбал:

<sup>3</sup> Д.Даваасамбуу, Я.Пүрэвээ, Ю.Батсайхан, Д.Гантөмөр, “Ашигт малмалын хөрөнгийн үнэлгээний онол, арга зүй”, 2018 он, Улаанбаатар, нүүр – 35.

<sup>4</sup> Д.Даваасамбуу, Я.Пүрэвээ, Ю.Батсайхан, Д.Гантөмөр, “Ашигт малмалын хөрөнгийн үнэлгээний онол, арга зүй”, 2018 он, Улаанбаатар, нүүр – 35.

- i. Талбайг нөөцөд авах тохиолдолд хохирол, нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд;
- ii. Газрыг тусгай хэрэгцээнд авах хохирол, нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд;
- iii. Тодорхой талбайд ашигт малтмал хайх, ашиглахыг хуулиар хориглох тохиолдолд хохирол, нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд;
- iv. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн давхацлыг арилгах хүрээнд хохирол, нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд;
- v. Тусгай зөвшөөрөл эзэмшигч сайн дурын үндсэн дээр талбайг бүрэн эсхүл хэсэгчлэн төрд буцаах хүрээнд;
- vi. Төрөөс тусгай зөвшөөрөл дуусгавар болгосон буюу хүчингүй болгосны улмаас маргаан үүссэн тохиолдолд гэх мэт.

Эдгээрээс (1) газрыг тусгай хэрэгцээнд авсан, (2) тодорхой талбайд ашигт малтмал хайх, ашиглахыг хуулиар хориглосон тохиолдолд нөхөх олговрыг олгохоор заасан байдаг. Тодруулбал, Ашигт малмалын тухай хуулийн 9.1.13-т зааснаар Засгийн газар нь “ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээнд авах зорилгоор төрийн мэдэлд шилжүүлэн авч нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохирсоны үндсэн дээр улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбай болон энэ хуулийн 26.9-д заасан талбайгаас тусгай зөвшөөрөл олгож болно” гэж заасан байгаа.

Түүнчлэн, Ашигт малтмалын тухай хуулийн 14.4 дэх хэсэгт хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн тусгай хэрэгцээнд авснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмал эрэх, хайх, ашиглах боломжгүй болсон бол тухайн шийдвэр гаргасан байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговрыг нэг жилийн дотор төлөхөөр, мөн хуулийн 14.5 дах хэсэгт, нөхөх олговрын хэмжээ, төлөх хугацааг тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн газрыг тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргасан байгууллага хоорондоо тохиролцон тогтоох бөгөөд тохиролцоонд хүрээгүй бол эрх бүхий хөндлөнгийн этгээдийн дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны байгууллага тогтооно гэж, 14.7 дах хэсэгт нөхөх олговортой холбогдсон маргаан гарвал шүүх хянан шийдвэрлэнэ гэж тус тус заасан байна.

Эдгээрээс дүгнэж үзвэл талбайг тусгай хэрэгцээнд авсан тохиолдолд төрөөс олгох нөхөх олговрын хэмжээг (1) талууд харилцан тохиролох байдлаар тогтоох, (2) хэрэв тохиролцож чадаагүй бол эрх бүхий хөндлөнгийн этгээдийн дүгнэлтийг үндэслэн төрийн байгууллага тогтоох ба (3) маргаан үүсвэл шүүхээс эцэслэн тогтоохоор байна.

Өөрөөр хэлбэл, нөхөх олговрын хэмжээг тогтоохдоо ашигт малтмалын үнэлгээг ашиглах эсхүл харгалзаж үзэх, эсхүл уг үнэлгээг заавал хийлгэх шаардлага үүсч болох юм. Ялангуяа, хуульд заасан “хөндлөнгийн этгээд” гэдэгт нэвтрүүлэхээр судалж буй “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ”-г гүйцэтгэх эрх бүхий мэргэжлийн төрийн бус байгууллага хамаарах талаар хуульд тодруулга хийж болох юм. Нөгөөтэйгүүр, шүүхээс маргаан шийдвэрлэх явцад мөн мэргэжлийн төрийн бус байгууллагаар ашигт малмалын хөрөнгийн үнэлгээг тогтоолгон шийдвэр гаргах ажиллагаандаа ашиглаж болно.

Харин тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сайн дурын үндсэн дээр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг төрд буцаан өгөх тохиолдолд нөхөх олговрын асуудал яригдахгүй тул үнэлгээ тогтоолгох хэрэгцээ, шаардлага төдийлөн үүсэхгүй болов уу.

## Тусгай зөвшөөрлөөс гадна орд ашиглахтай холбоотой гэрээ, хэлцэл байгуулах гэх мэт гэрээт харилцааны хүрээнд

Дээр дурдсан тусгай зөвшөөрөл олгох нэг талын эрх давамгайлсан аргачлалаас гадна, Монгол Улсын эрдэс баялгийн хууль тогтоомжид зарим төрлийн ашигт малтал, эсхүл зарим ангилалын ордын тухайд бүтээгдэхүүн хуваах, хамтран ашиглах гэх мэт хэлэлцээнд гэрээ, хэлцэл байгуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах эрх нь бүрэн олгодох хуулийн зохицуулалт байна. Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуульд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тухайд орд ашиглах гэрээг байгуулах, газрын тосны тухайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах гэх мэт тохиолдлууд байна. Эдгээрийн харилцааны хүрээнд талуудын тэгш байдлыг хангах хүрээнд хөндлөнгийн байгууллагаар гэрээний зүйл болох тодорхой ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг тогтоолгон ашиглаж болох юм.

Ялангуяа, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тухайд төрийн оролцооны хувь хэмжээг улсын төсвөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон эсэхээс хамааруулж төрийн оролцоог 34 хүртэл, эсхүл 50 хүртэл хувиар тогтоож болохаар заасан байх ба тухайлсан хувь хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлох эсхүл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болохоор тус тус заасан байна. Энэ хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>2</sup> дах заалтын дагуу төр нь өөрийн эзэмшлийн тодорхой хувь, хэмжээг гэрээний нөгөө талдаа шилжүүлэн, үүний хариуд 5 хүртэл хувиар Засгийн газраас тогтоох ашигт малтмал ашигласны төлбөрийг улсын төсөвт төлөхөөр заасан байна. Энэ хүрээнд тухайн “ордын онцлог”-ийг хамаарч хувь хэмжээг тогтоохоор заасан байх ба уг “онцлог” гэдэгт ямар хүчин зүйлүүдийг хэрхэн харгалзах, үнэ, үнэлгээний тухайд ямар үнэлгээ ашиглах талаар тодорхойгүй байна.

Эндээс дүгнэж үзвэл, ашигт малтмалын орд дах төрийн оролцооны хувь хэмжээг тогтоох, орд ашиглах гэрээ байгуулах, эсхүл төрийн оролцоог төлбөрөөр орлуулах гэх мэт асуудлын хүрээнд нэвтрүүлэхээр судалж буй ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодексыг ашиглах боломж байна гэж үзэж болох хэдий ч дээрх асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх нарийвчилсан горим байхгүй, орд ашиглах гэрээний хэлэлцээг хэрхэн хийх, төлбөрийн хэмжээг юунд үндэслэн тодорхойлох зэрэг нь тодорхой бус байгаа нь хэлэлцээ хийгч талуудын тухайд дундын аргачлал дээр сайн дураараа харилцан тохиролцсон тохиолдолд л үнэлгээний код, стандартыг ашиглах боломжтой байдалд үүсэхээр байна.

Мөн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжина хэмээн Ашигт малтмалын тухай хуулийн 5.6 дах хэсэгт заасан байгаа хэдий ч өнөөг хүртэл уг шаардлагыг биелүүлсэн тохиолдол гараагүй байна. Хэрэв гарах тохиолдолд өмнөх бүлэгт дурдсанчлан үнэт цаасны хууль тогтоомжийн хүрээнд үнэт цаасны танилцуулгад ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайлан, мэдээллийг тусгадаг болгох бүрэн боломжтой байгаа.

Эдгээрээс гадна улс орны онцлогтой холбоотой “бичил уурхай эрхлэх”, “үүсмэл орд ашиглах”-тай зохицуулалтын эрх зүйн үндэслэлийг Ашигт малтмалын тухай хуульд мөн тусгаж өгсөн байдгийг дурдах нь зүйтэй.

Эдгээр харилцааны хүрээнд яригдаж буй ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодексыг ашиглах хэрэгцээ гарахыг үгүйсгэж болохгүй юм. Тодруулбал, үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор иргэдийн хамтран байгуулсан нөхөрлөл, хоршооны хэлбэрээр ашиглах бичил уурхайн үйл ажиллагааны хүрээнд болон олборлолт, боловсруулалт, баяжуулалтын явцад ялгагдсан ашигт малтмалын тодорхой агуулга бүхий дахин боловсруулахад

эдийн засгийн үр ашиг гаргаж болохуйц хүдэр, ашигт малтмалын овоолго зэрэг үүмэл ордоос ашигт малтмал ялган авах, боловсруулах, баяжуулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг үүсмэл орд ашиглах зохицуулалтын хүрээнд эрхэлж болохоор байгаа.

#### Төрийн зохицуулалт, хариуцлагатай уул уурхайн хүрээнд ашиглах боломжийн тухайд

Хариуцлагатай уул уурхайн салбарыг хөгжүүлэх хүрээнд хууль тогтоомж зөрчсөн, байгаль орчинд хохирол учруулсан, уул уурхайн үйл ажиллагааг зохих ёсоор эрхлээгүй гэх мэт тохиолдолд хариуцлага тооцох хэрэгцээ шаардлагын хүрээнд үнэлгээ тогтоох хэрэгцээ үүсч болох юм.

Тухайлбал, тодорхой орд дах үндсэн болон дагалдах ашигт малтмалын бүрэн дүүрэн, цогцоор нь ашиглаагүй, хаягдал дах ашигт малтмалын агууламжийг бүрэн ялгаж аваагүй гэх мэт эрдэс баялгийн салбарын уул, технологийн хүрээнд уг хэрэгцээ шаардлага үүсч болох юм. Жишээлбэл, тодорхой ордын уулын ажлын төлөвлөлтийг буруу хийсний улмаас газрын хэвлий дэх зарим хуримтлалыг ашиглах нь технологийн хувьд боломжгүй болох эсхүл эдийн засгийн тооцооллын хувьд ашиггүй болох нөхцлийг бүрдүүлсэн байж болно.

Хамгийн ойрын жишээ бол ордын биед дээр хаягдлын далан байгуулах, суурьшлын бүс байгуулах эсхүл нээлттэй уурхайн байгуулалтыг буруу байгуулсан гэх мэт тохиолдлуудад ашиглах боломжгүй болгосон хэсгийн үнэлгээг тогтоох хэрэгцээ гарч болох юм.

Өнөөгийн байдлаар, Ашигт малтмалын тухай хуулийн 66.4 дэх хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаандаа химийн хорт бодис, бэлдмэлийг хэрэглэхдээ хууль, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг дагаж мөрдөөгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд ноцтой хохирол учруулсан бол тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу цуцалж, 20 жилийн хугацаанд дахин тусгай зөвшөөрөл олгохгүй гэж заасан байдаг.

Мөн, Газрын хэвлийн тухай хуулийн 20.2.1-д газрын хэвлий ашглагч нь газрын хэвлийн геологийн судалгааг бүрэн хийлгэж, зөв зохистой, иж бүрэн ашиглах, хамгаалах үүрэгтэй байхаар, мөн хуулийн 32 дугаар зүйлд газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглахад (1) үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, түүний үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий бүрэлдэхүүн хэсгийг үр ашигтай иж бүрэн, бүрэн гүйцэд олборлох аргыг хэрэглэх, (2) ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, ордын зөвхөн баялаг хэсгийг нь сорчлон олборлохгүй байх; (3) ашигт малтмалын ордод хийвэл зохих гүйцээх болон ашиглалтын хайгуул, геологийн бусад ажил, түүнчлэн ашиглалтын геологи, маркшейдерийн ажлыг бүрэн гүйцэтгэж, техникийн зохих баримт бичгийг гүйцэд хөтлөх, (4) ашигт малтмалын нөөцийн байдал, хөдөлгөөн, хаягдал, бохирдлыг тооцож байх, (5) уулын ажлын явцад ашиглаж байгаа болон түүнтэй зэрэгцэн оршиж байгаа ордыг гэмтээхгүй байх, нөөцөд үлдээсэн ашигт малтмалыг хадгалж хамгаалах, (6) үйлдвэрлэлийн явцад дайвраар олборлосон бөгөөд ашиглаагүй байгаа ашигт малтмал, ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэх, хадгалах, (7) уулын малталтын чулуулаг, үржил шимтэй хөрс, үйлдвэрлэлийн хаягдлыг зөв зохистой ашиглах байршуулах зэрэг үүргийн хэрэгжилтийг тодорхойлох хүрээнд зөрчлийн улмаас ашиглаагүй, эсхүл дутуу ашигласан ашигт малтмалын үнэлгээг тогтоох хэрэгцээ шаардлага үүсч болох юм.

Түүнчлэн, Газрын хэвлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт эрдэс түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл (1) олборлосон эрдэс түүхий эдээс үйлдвэрийн ач холбогдол бүхий бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн, бүрэн гүйцэд ялган авч чадахуйц технологи хэрэглэх, (2) боловсруулалтын хаягдлыг бүрэн гүйцэд ашиглах, (3) ашигтай бүрэлдэхүүн хэсгийг

агуулсан бөгөөд ашиглаагүй байгаа үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэх, хадгалж хамгаалах шаардлагыг хангасан байхаар заасан байдаг. Эдгээр шаардлагын хэрэгжилтийг тодорхойлж, зохистой байдлаар шаардлагын хүрээнд ашиглаж чадаагүй ашигт малмалын хөрөнгийн үнэлгээг тогтоох тохиолдолд нэвтрүүлэхээр яригдаж буй МонВал үнэлгээний үндэсний кодекссыг онолын хувьд хэрэглэж болохоор байна.

### **3.3.2. Аж ахуйн харилцааны явцад ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ тогтоох боломжийн талаар**

Эрдэс баялгийн тухай хууль тогтоомжийг нягтлавал, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь аж ахуйн үйл ажиллагаагаа эрхлэх хүрээнд тусгай зөвшөөрлөөр хайх эсхүл ашиглах эрх олгогдсон ашигт малмалын хөрөнгийн үнэлгээг өөрөө шаардлагатай гэж үзвэл сайн дурын үндсэн дээр, өөрийн дотоод бизнесийн зорилгоор тогтоолгох бүрэн боломжтой. Уг асуудлыг хуулиар хориглосон, хязгаарласан зүйл байхгүй байна.

Суурь зарчмын хувьд ашигт малтмал хайх эсхүл ашиглах тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь тухайн тусгай зөвшөөрлөөр эрх олгогдсон ашигт малмалын орд, эрдэс баялгийн хуримтлалыг судлах бүрэн эрхтэй байх ба энэ хүрээндээ зах зээлийн үнэ цэнийг өөрөө эсхүл мэргэжлийн хөндлөнгийн этгээдээр тогтоолгох боломжтой юм. Өөрөөр хэлбэл, ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ тогтоолгож байгаа үйл явцыг ашигт малмалын ордын нөөцийг тогтоолгох болон техник, эдийн засгийн үндэслэлийг бэлтгэхтэй адилтган үзэж болно.

Ашигт малтмалын тухай хуулийн долдугаар бүлгээр буюу 49-52 дугаар зүйлээр тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, барьцаалах боломжийг хягаартайгаар хүлээн зөвшөөрсөн байгаа. Тодруулбал, Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.21 дэх заалтаар тодорхойлсон “тусгай зөвшөөрөл эзэмшигч”-ийн тодорхойлолтын агуулгаас үзвэл тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу хуулийн этгээд шилжүүлэн авч болохоор заасан байх ба мөн хуулийн 21.1.4 болон 27.1.6 дах заалтуудад заасанчлан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрлийг хуулийн шаардлагыг хангасан байдлаар бусдад шилжүүлэх, барьцаалах эрхтэй байхаар тус тус заасан.

Агуулгын хувьд тусгай зөвшөөрлийг үндсэндээ арилжааны зарчмаар бусдад шилжүүлж болох (энд тусгай зөвшөөрлийг төрд шилжүүлэх талаар тусгаагүй) тохиолдолуудыг мөн чанараар нь авч үзвэл нэвтрүүлэхээр судалж буй үнэлгээний үндэсний код, стандартыг дараах байдлаар ашиглах тохиолдол гарч болох юм. Үүнд:

- i. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Иргэний хууль, Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай хуульд заасны дагуу нэгдэх, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шинээр бий болсон эрх хүлээн авагчид, түүнчлэн хараат, охин компани нь толгой компанидаа тусгай зөвшөөрлийг шилжүүлэхэд. (АМТХ-ийн 49.1.)
- ii. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрэл, хайгуулын талаархи анхдагч материал, тайлан зэрэг мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж зохих албан татвар төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд түүний эзэмшилд байсан тусгай зөвшөөрлийг худалдан авагчид нь шилжүүлэх үед. (АМТХ-ийн 49.2.)
- iii. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, баримт бичгийн хамт холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж зохих албан татвар төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд түүний эзэмшилд байсан тусгай зөвшөөрлийг худалдан авагчид нь шилжүүлэх үед. (АМТХ-ийн 49.3.)
- iv. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааг шууд болон шууд бусаар шилжүүлэх, эцсийн эзэмшигч өөрчлөгдөх тохиолдолд хувьцаа худалдаж байгаа



болон худалдан авч байгаа талууд сайн дураараа гүйцэтгүүлж болох юм. (АМТХ-ийн 49.12)

- v. Барьцаалуулагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл барьцаалуулсан байгаа тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болох тохиолдолд барьцаалагчийн хүсэлтийн дагуу тусгай зөвшөөрлийг шаардлага хангасан бусад хуулийн этгээдэд шилжүүлэх үед (АМТХ-ийн 52 дугаар зүйл)
- vi. Тухайлан шууд утгаар нь зааж өгөөгүй ч тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааныг шүүхээр шийдвэрлэх боломжтой байгаатай холбоотой шүүхийн шийдвэрийн дагуу бусдад шилжүүлэх боломжтой ба энэ хүрээнд үнэлгээний асуудал яригдаж болох юм. (АМТХ-ийн 49.10)

Харин тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Иргэний хууль, Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай хуульд заасны дагуу хуваагдах, тусгаарлагдах замаар өөрчлөн байгуулагдсан тохиолдолд тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны байгууллагад буцааж өгөхөөр заасан байх ба уг тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах журмаар буцаан олгохоор заасан байна. Гэхдээ, тусгай зөвшөөрөл эзэмшигч уг тусгай зөвшөөрлийг дахин авах давуу эрх эдлэхээр байна.

Дээр дурдсан үндсэн 6 тохиолдлоос эхний дөрвөн тохиолдлын тухайд хуулиар тухайлан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.14 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу тооцсон үнэ, тайлбар, танилцуулгыг эрх бүхий төрийн байгууллагад ирүүлэхээр заасан байна (АМТХ-ийн 49.4.8 дах заалт). Өөрөөр хэлбэл, татвар ногдуулалт, төлөлттэй холбоотой төрийн эрх ашгийн хүрээнд төрийн байгууллагад заавал үнэлгээ хийлгэж ирүүлэхийг шаардсан байгаа.<sup>5</sup>

Харин, тав дах тохиолдол болох тусгай зөвшөөрлийн барьцаалсантай холбоотой хийгдэх шилжүүлгийн тухайд тухайд Ашигт малмалын тухай хуулийн 51.1 дэх хэсэгт хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилт олох, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхийн тулд тусгай зөвшөөрлийг эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, геологийн судалгааны мэдээлэл, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг холбогдох баримт бичиг болон хууль тогтоомжоор барьцаалахыг хориглоогүй эд хөрөнгийн хамтаар зөвхөн банк, банк бус санхүүгийн байгууллагад барьцаалж болох бөгөөд тусгай зөвшөөрөл нь дангаараа барьцааны зүйл болохгүй гэж заасан байна.

Мөн, барьцааны үүргийн гүйцэтгэлтэй холбоотойгоор барьцаалагч болох банк, санхүүгийн байгууллагын оролцоо, хүсэлтийн дагуу хэн нэг гуравдагч этгээдэд тусгай зөвшөөрлийг шилжүүлэх боломж нээлттэй. Энэ нь банк, санхүүгийн байгууллага нь тус бүрийн нарийвчилсан зохицуулалтын хүрээнд банк, санхүүгийн ажил үйлчилгээнээс өөр бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон байдаг, банкуудад хөрөнгийн болон үйл ажиллагааны зохистой харьцааны хязгаарлалтууд байдагтай холбоотой.

Ашигт малтмалын тухай хуулийн 52 дугаар зүйлийн дагуу барьцааны үүрэг болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн хүрээнд хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой

---

<sup>5</sup> Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталсан ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн үнэлгээний үнийг дүнг, тайлбар, тодруулгын хамт ирүүлэхээр заасан байгаа. Сангийн сайдын зүгээс 2017 онд 380 тоот тушаал гарган “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, тусгай зөвшөөрөл шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах аргачлал”-ыг баталсан. 2020 оноос дагаж мөрдөж байга татварын багц хуулийн шинэчлсэн найруулгаар тусгай зөвшөөрлийн үнэлгээг тогтоох аргачлалыг Сангийн сайд батлах зохицуулалт хэвээр үргэлжлэхээр байгаа болно. Олон нийтэд танилцуулаад байгаа аргачлалын агуулгын талаар татварын хэсэгт дэлгэрэнгүй дурдана.

дараах хоёр тохиолдолд барьцааны зүйл болсон тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлж болно. Үүнд:

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээргүй, буюу биелүүлээгүй тохиолдолд, эсхүл
2. Ашигт малтмалын хуульд зааснаар хайгуулын эсхүл ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болох нөхцөл бүрдсэн тохиолдолд төрийн захиргааны байгууллага энэ тухай барьцаалагчид мэдэгдэх бөгөөд барьцаалагч нь мөн хуулийн 7.1-д заасан тусгай зөвшөөрөл эзэмших боломжтой этгээдэд тусгай зөвшөөрлийг шилжүүлэх саналыг тэргүүн ээлжинд гаргасан тохиолдолд.

Энэ хүрээнд барьцаалагчийн зүгээс тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авах хуулийн шаардлага хангасан этгээдтэй хэлэлцээ хийх, ашигт малтмалын үнэлгээг тогтоолгох шаардлага үүсч болох ба талаар тухайлсан Ашигт малтмалын тухай хуульд нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Эдгээрээс гадна, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нэмэж үнэт цаас гаргах байдлаар хөрөнгө оруулалт татах замаар шууд бус байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн хүрээг тэлэх, өргөжүүлэх, өөрчлөх боломж нээлттэй байгаа. Заавал хувьцаагаар хязгаалагдахгүйгээр, шууд болон шууд бус байдлаар хувьцаанд хөрвөх өөр бусад санхүүгийн хэрэгсэл гаргах, саналын эрхийг бусдад шилжүүлэх нөхцөлтэй гэрээ хэлцэл байгуулах гэх мэт хуулийн этгээдийн нэгдэл, группын бүтэц зохион багуулалтаар дамжуулан тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх, хяналт, үр өгөөж хүртэх эрхийг бусдад шилжүүлэх боломжууд нээлттэй байдаг. Эдгээр харилцаанд судлагдаж буй ашигт малтмалын үнэлгээний үндэсний кодексийг сайн дурын үндсэн дээр ашиглах бүрэн боломжтой.

### **3.3.3. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг тогтоохтой холбоотой татварын зохицуулалтын талаар**

Монгол Улсын Их хурлаас өнгөрөгч 2019 оны 3 дугаар сард Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль зэрэг татварын гол гол хуулиудыг шинэчлэн баталсан нь 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхлээд байна.

Тус хууль тогтоомжид ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээтэй хамааралтай туссан нэг зохицуулалт бол ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн эзэмшил дэх хувьцаа, хувь оролцоог шууд бусаар бусдад шилжүүлэх замаар олж байгаа эрх борлуулсны орлогод орлогын албан татвар ногдуулахтай холбоотой зохицуулалт байна.

Тодруулбал, Татварын ерөнхий хуулийн 6.1.48 дах заалтаар “эцсийн эзэмшигч” гэж ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээдийн 30 болон түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг өөрөө, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр төлөөлүүлэн эзэмшдэг, саналын эрхийг төлөөлүүлэн хэрэгжүүлдэг, эсхүл ногдол ашгийг хүлээн авах эрхтэй этгээдийг ойлгохоор тодорхойлсон байгаа.

Улмаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаар “эцсийн эзэмшигч”-ийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эрх

эзэмшигч аж ахуйн нэгжийн “төрийн байгууллагаас олгосон эрх борлуулсан, шилжүүлсний орлого”-д тооцон 10 хувийн татвар ногдуулахаар заасан.

Ингэхдээ албан татвар ногдуулах орлогын суурийг Сангийн сайдын баталсан журмын дагуу тооцсон тухайн эрх, тусгай зөвшөөрлийн үнэлгээнээс доор дурдсан баримтаар нотлогдох зардлуудыг хасаж тодорхойлох ба уг сууриас “эцсийн эзэмшигч”-ийн тухайлан борлуулсан, шилжүүлсэн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхээс эрх эзэмшигчийн хувьцаанд хамаарах хэмжээгээр тухайн эрхийн үнэлгээнээс хувь тэнцүүлэн тооцож, албан татвар ногдуулах орлогыг эцэслэн тодорхойлохоор заасан байгаа. Хасч тооцож болох нотлогдох зардалд (1) төрийн байгууллагаас эрх олгосон тохиолдолд эрх авахтай холбогдон төрийн байгууллагад төлсөн баримтаар нотлогдох төлбөр, хураамж, (2) бусдаас худалдаж, шилжүүлж авсан тохиолдолд хэлцлийн дагуу худалдах, шилжүүлэн авахад төлсөн, шилжүүлсэн баримтаар нотлогдох төлбөр байгаа болно.

Гэхдээ, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.7, 30.8 болон 30.9 дэх хэсгүүдээр хэрэв (1) тухайн эрх борлуулсны орлого нь хувьцаа борлуулсны орлоготой давхардах бол аль өндөр дүнтэй орлогод татварыг давхардуулахгүйгээр ногдуулах, (2) тодорхой нэгдлийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж байгаа буюу бодитой хэн нэгэнд хувьцаа, хувь оролцоо шилжээгүй бол татвар ногдох харилцаа гэж үзэхгүй байх (3) тухайн нэгдлийн гишүүн нь хөрөнгийн биржид бүртгэлтэй бол хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн 20 хүртэлх хувийн хөдөлгөөнд татвар ногдуулахгүй байх онцлог зохицуулалтууд ч мөн туссан байна.

Тус хуулийн 30.6 дах заалтаар тус эрх борлуулсны орлогод албан татвар ногдуулах журам, газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлалыг тус тус санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан байгаа. Энэхүү судалгааг гүйцэтгэх үед эдгээр журам, аргачлал батлагдсан тухай нийтэд мэдээлэл гараагүй бйасан тул агуулгынх нь талаар дэлгэрэнгүй авч үзэх боломжгүй байна.

Гэхдээ, Татварын ерөнхий газраас нийтэд танилцуулсан хувилбар болон өмнө 2017 онд Сангийн сайдын 380 дугаар тушаарлаар батлан мөрдүүлж байсан үнэлгээний аргачлалууд нэвтрүүлэхээр яригдаж буй МонВал кодексоос зарчмын ялгаатай буюу үндсэндээ үнэлгээг техник, эдийн засгийн үнэлгээнд заасан мөнгөн урсгалын үнийн дүнгийн хэмжээгээр тооцохоор заасан байсан.

Тайлагналын тухайд “эцсийн эзэмшигч”-ийн өөрчлөлтийн тухай мэдээллийг шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор харьяалах татварын албанд бүртгүүлэх ба эрх эзэмшигч хуулийн этгээдэд 30 хоногийн дотор улсын төсөвт төлж тайлагнах нийтлэг үүрэг хүлээлгэсэн байгаа. Гэхдээ, хувьцаа нь гадаад, дотоодын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагддаг бол “эцсийн эзэмшигч”-ийн өөрчлөлтийн тухай мэдээллийг татварын албанаас баталсан маягтын дагуу тухайн жилийн 07 дугаар сарын 20-ны өдөрт багтаан, жилийн эцсийн мэдээллийг дараагийн татварын жилийн 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харьяалах татварын албанд бүртгүүлэхийн хамт төлж болохоор заасан байна.

Нэгэнт, энэхүү татварын зорилгоор тодорхойлох ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн үнэлгээ нь нэвтрүүлэхээр судлагдаж буй МонВал-ын кодексоос зориулалт болон үнэлгээ тогтоож байгаа зарчим, аргачлалын хувьд эрс ялгаатай тул энэхүү ялгааг маш ойлгомжтой байдлаар тэмдэглэн, хэрэглээг нь хольж хутгахгүй байх нөхцлийг бүрдүүлж ажиллахыг зөвлөж байна.

### **3.3.4. Нэр томъёоны тухайд**

Нэр томъёоны хувьд олон улсын хэмжээнд ашиглаж байгаа “mineral asset valuation” гэх томъёолол нь бүх төрлийн ашигт малтмалыг хамруулсан байдлаар тэдгээрийг эрэх, хайх, ашиглах эрхтэй нь ойлгон ашиглаж байгааг харгалзан манай улсын үндэсний кодексийн хүрээнд холбогдох тодруулгыг ашиглах нь зүйтэй болов уу. Учир нь манай орны хууль тогтоомжийн бүтэц, зохион байгуулалт, зохицуулах харилцааны хүрээ өөр өөр байгаагаас хамаарч зарим нэр томъёог явцуу байдлаар ашиглах эрсдэл гарч болох юм.

Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 3.1 дэх хэсэгт тус хуулиар ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахаар заасан байдаг ба бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулахаар заасан байдаг зэрэгтэй холбоотой МонВал-д ашигласан “ашигт малтмал” гэх ойлголтод газрын тос, цацраг идэвхт бодис гэх мэт бүхий л төрлийн ашигт малтмал бүрэн хамаарч байгаа болох тусгах эсэхийг нягтлан шийдвэрлэхийг зөвлөж байна.

Судлаачийн зүгээс хууль тогтоомжид заасан дараах нэр томъёог МонВал-ын тухайд хэрхэн ашиглах талаар нарийвчлан нягталж, аливаа ойлголтын зүүрүү үүсгэхгүй байдлаар буюу МонВалын хэрэглээний хүрээг хязгаалахгүй байдлаар боловруулж, шаардлагатай тодруулга, тайлбартай боловсруулахыг зөвлөж байна.

Ялангуяа, ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний бодитой байдлыг хангах шаардлагатай уялдуулж тодорхой ашигт малтмалын нөөцийг эцэслэн эсхүл ядаж урьдчилсан байдлаар тогтоосон байх буюу нөөцийн үнэмшил тодорхой түвшинд баталаажсан байх шаардлагыг тэмдэглэсэн байна. Энэ байдлыг Монгол Улсын хууль тогтоомжид буулгавал “ашигт малтмалын орд” болон “ашигт малтмалын ордын нөөц” гэх ойлголтыг хэрэглэх нь зөвлөж байна.

Өөрөөр хэлбэл, тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон, үйлдвэрийн аргаар олборлох боломжтой, эдийн засгийн үр ашигтай, баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдсон ашигт малтмалын баялгийн хэсэг бүхий тусгай зөвшөөрлөөр баталгаажсан нөөцийн тухайд зах зээлийн үнэлгээ тогтоох нь үнэлгээний бодитой байдлыг дээшлүүлэх юм.

Харин нөөц нь тогтоогдоогүй, тусгайлан орд гэж тооцоогүй байгаа хайгуулын тайлбайн тухайд МонВал-д үнэлгээ өгч болох хэр хэмжээ, судлагдсан байдлын шалгуурыг нэмэлт тодруулга байдлаар тусгах нь зүйтэй болов уу.

Түүнчлэн, МонВал нь баримт бичгийн нэршлийн тухайд “кодекс” эсхүл “стандарт”-ын аль нэр томъёог ашиглах нь илүү оновчтой байх асуудлын тухайд судлаачийн зүгээс “үндэсний кодекс” хэмээх нэршлийг ашиглахыг зөвлөж байна. Өөрөөр хэлбэл, тус бичиг баримтыг ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээгээр мэргэшсэн төрийн бус байгууллага бэлтгэн, баталж байгаа олон улсын жишиг, дагаж мөрдөхөд нь мэргэжлийн хүрээллийн арга зүй, ёс зүй шаардлага, хяналт ихээхэн чухал байдаг зэрэг зүй зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чухал байгааг нэг тэргүүнд харгалзаж үзэхийг зөвлөж байна.

Үүнээс гадна, “стандарт” гэх нэршлийг ашиглах тохиолдолд тус бичиг баримтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль тогтоомжийн дагуу стандартчиллын ямар төрлийн бичиг баримт болохыг тогтоолгох шаардлага үүсэхээр байна. Төрлийн хувьд “үндэсний стандарт”, “байгууллагын стандарт” болон “гадаад улсын стандарт” гэх гурван төрлийн стандарт байх боломжтой байна.

Эдгээрээс хэрэв, “үндэсний стандарт” байна гэж үзвэл уг стандартыг эрх бүхий төрийн байгууллагаар батлуулах шаардлага үүсэх ба энэ нь тус баримт бичгийн хэрэглээнд сөрөг нөлөө үзүүлж мэдэх юм. Ялангуяа, засаглалын хувьд холимог хэлбэрийн нөлөөлөл бий болгох боломжтой ба ингэснээр ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ тогтоох ажил, үйлчилгээний мэргэшсэн байдал, чанарт сөргөөр нөлөөлөх, тухай бүр үнэлгээний мэргэжлийн байгууллагын зүгээс шаардлагатай засан сайжруулалтыг хийх, нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг хязгаарлан, тус кодексийн уян хатан байдал, үр нөлөөг алдагдуулж болох юм. Хэрэв, “байгууллагын стандарт” байна гэж үзвэл Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар “байгууллагын стандарт”-тай холбоотой зохицуулалт нь маш товч байгаагаас үр нөлөө, ач холбогдлын талаар дэлгэрэнгүй авч үзэх боломжгүй байна.

Харин, “кодекс” гэх нэршлийн тухайд уг нэршлийг ашиглаж байгаа туршлага Монгол Улсад байна. Тодруулбал, Хорооны зүгээс олон улсын нийтлэг жишгийн дагуу 2007 онд үндэсний хэмжээнд мөрдөгдөх “Компанийн засаглалын кодекс”-ийг батлан мөрдүүлж эхэлсэн байх ба тус кодексийг 2014 онд 162 дугаар тогтоол гарган шинэчлэн баталсан байх ба одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

### **Дөрөв. Дүгнэлт, зөвлөмжүүд**

Олон улсын жишиг, чиг хандлагын хувьд “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодекс”-ийг тодорхойлох, үнэт цаасны зах зээлд нээлттэй тайлагналын хувиар хэрэглэхтэй холбоотой дараах үндсэн шинж чанарыг тэмдэглэж байна. Үүнд:

1. “Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодекс”-ийг тухайлан ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний чиглэлээр мэргэшсэн шинжээч-үнэлгээчдээс бүрдсэн мэргэжлийн байгууллага боловсруулан баталдаг байх ба тус төрийн бус байгууллага нь тухай бүр кодексоо засан сайжруулж, нэмэлт өөрчлөлт оруулан, хэрэгжилтийг нь ханган ажилладаг байна.
2. Тус үнэлгээний кодексийг хөрөнгийн зах зээлд дагаж мөрдөхтэй холбоотой шийдвэрийг тухайн үнэт цаасны зах зээлийн эрх бүхий зохицуулах байгууллага, хөрөнгийн биржийн зүгээс “хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөх” зарчмаар нэвтрүүлж, өөрийн үнэт цаасны бүртгэлийн журамд шаардлагатай зохицуулалтыг тусгаж ашиглах нөхцлийг бүлдүүлэн ажиллаж байна. Ашигт малтмалын нөөцийн тайлагналын кодекскуудыг ч мөн энэ зарчмаар үнэт цаасны зах зээлүүд дээр хүлээн зөвшөөрч ашиглаж байна.

3. Зориулалтын хувьд тус үнэлгээний кодексе нь тухайн цаг үе дэх тодорхой ашигт малтмалын нөөц, хуримтлалын зах зээлийн үнэ цэнийг тодорхойлж, хөрөнгө оруулагчдад аль болох үнэн зөв мэдээллийг нээлттэй хүргэх замаар хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилготой байдаг байна.
4. Тус үнэлгээнд ашигт малтмалтай холбоотой эрх эзэмшигч хуулийн этгээдийн өөрийн хөрөнгийн үнэ цэнийг оруулдаггүй, дан ганц ашигт малтмалын хөрөнгө буюу газрын хэвлийд байгалийн байдлаараа байгаа хайх, ашиглах эрх бүхий ашигт малтмалын нөөц, хуримтлалын үнэ цэнийг дангаар нь тодорхойлдог онцлогтой байна.
5. Бодитой байх шаардлагын хүрээнд аль болох нөөц нь тодорхойлогдсон эсхүл харьцангуй сайн судлагдсан орд, хуримтлал бүхий талбайн талаар нөөцийн тайлан, судалгаанд түшиглэдэг байна.
6. Тус үнэлгээний тайланг хараат бус, хөндлөнгийн бөгөөд мэргэшсэн шинжээч гүйцэтгэх ба маш энгийн, ойлгомжтой байдлаар хийгдсэн байдгаараа “техник, эдийн засгийн үндэслэл”-ээс агуулга, хэлбэр хийгээд зориулалтын хувьд ялгаатай байдаг байна.

Судалгааны үр дүнд Монгол Улсын эрх зүйн орны талаар дараах дүгнэлтэд хүрсэн болно.

Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хороо болон өөрийгөө зохицуулах эрхтэй байгууллага болох Хөрөнгийн биржийн зүгээс “МонВал”-ыг олон улсын жишгийн дагуу хүлээн зөвшөөрч нээлттэй тайлагналын зорилгоор ашиглахыг зөвшөөрөх бүрэн боломжтой байна. Тодруулбал, Хороо нь бүрэн эрхийнхээ хүрээнд ҮЦЗЗТХ-ийн 63.1.2, 63.1.4, 63.1.11 дах заалтын хүрээнд Хороо нь дүрэм, журмыг батлах, зөвшөөрөл олгох бүрэн эрхийнхээ хүрээнд МонВалыг хүлээн зөвшөөрөх, үнэт цаасны зах зээлд ашиглах болон Хөрөнгийн биржийн Бүртгэлийн журамд тусган мөрдүүлэх зөвшөөрлийг Хөрөнгийн биржид олгох эрхтэй байна.
2. Манай улсын Хөрөнгийн үнэлгээний хуулийн зохицуулалтад “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ” хамаарч байгаа эсэхийг нягтлах шаардлагатай. Үүнээс хамаарч, ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг ямар тохиолдолд, ямар хугацаанд хэрхэн гүйцэтгүүлэхтэй холбоотой нарийвчилан нөхцөл, шаардлагыг Хороо болон Хөрөнгийн биржээс тогтоох хэрэгцээ, шаардлага тодорхойлогдохоор байна.
3. ҮЦЗЗТХ-ийн дагуу “хөрөнгийн үнэлгээ”-ний үйл ажиллагаа нь бүртгэлийн үндсэн дээр эрхлэх зохицуулалттай үйл ажиллагаанд хамаарч байна.

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг үнэт цаасны зах зээлд гүйцэтгэх эрх бүхий этгээдийн хувь үнэлгээчин болон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь ҮЦЗЗТХ-ийн 63.1.6-ийн хүрээнд Хороонд бүртгүүлсний үндсэн дээр үнэт цаасны зах зээлийн оролцогчдод үнэлгээний үйлчилгээ үзүүлж болохоор байна. Харин үнэлгээг хувь үнэлгээчин гүйцэтгэх үү, эсхүл тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэх үү гэх асуудлын тухайд одоо хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу хувь үнэлгээчин гүйцэтгэж болохоор байгаа бол ҮЦЗЗТХ-д тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх агуулга байгааг нягталж хууль тогтоомжийн уялдааг сайжруулах хэрэгтэй байна.

Олон улсын жишгийн дагуу ашигт малмалын нөөцийн тайлан болон ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагаас эрх авсан хувь үнэлгээчин гүйцэтгэж байгааг анхаарах хэрэгтэй.

4. Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хуулиудад “ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ”-г буюу газрын хэвлийд байгалийн байдлаараа байгаа эрх, хайх, ашиглах эрх бүхий тодорхой орд, эрдсийн хуримтлалын зах зээлийн үнэлгээг тогтоолгох явдлыг шууд хориглосон эсхүл хязгаарласан зүйл заалт байхгүй байх ба тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд тусгай зөвшөөрөл бүхий талбайг судлах нийтлэг эрх хэмжээнийхээ хүрээнд үнэлгээг тогтоох буюу тогтоолгох боломжтой гэж үзсэн болно.
5. Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжид заасан тусгай зөвшөөрөл, эрх олголттой холбоотой харилцаа хийгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс явуулах бизнесийн бусад харилцааны хүрээнд ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг сайн дурын үндсэн дээр, дотоод хэрэгцээний тулд тогтоолгох эсхүл төр-хувийн хэвлийн хоорондын харилцааны явцад харилцан тохиолцсоны үндсэн дээр тогтоолгон ашиглах үйл боломж нээлттэй байна.

Энэхүү судалгааны хүрээнд дор дурдсан зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс “МонВал”-ыг үнэт цаасны зах зээлд дагаж мөрдөхтэй холбоотой шийдвэрийг гаргаж, Хөрөнгийн биржид өөрийн Үнэт цаасны бүртгэлийн журмаар зохих зохицуулалтыг бий болгохыг даалгах буюу бүртгэлийн журамдаа оруулах өөрчлөлтийг нь зөвшөөрөх байдлаар үнэт цаасны зах зээлд ашигт малтмалын хөрөнгийн үндэсний үнэлгээний кодексийг олон улсын жишгийн дагуу нээлттэй тайлагналын зориулалтаар нэвтрүүлэх бүрэн боломжтой байна.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд МонВал-ын талаар танилцуулж банкны салбарт хэрэглэдэг болох нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр санал, санаачлагатай ажиллахыг мөн зөвлөж байна.

Хөрөнгийн биржийн тухайд тухайд одоо мөрдөж байгаа Үнэт цаасны бүртгэлийн журмдаа өөрчлөлт оруулж “ашигт малмалын нөөцийн тайлан” болон “ашигт малмалын хөрөнгийн үнэлгээ”-г тус биржийн бүх ангилалын тухайд нийтлэг байдлаар шаарддаг болгохоос гадна ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг ямар тохиолдолд, ямар хугацаанд, хэрхэн гүйцэтгэж байх явцын шаардлагыг илүү тодорхой болгон тусгахыг зөвлөж байна.

Энэ хүрээнд 2010 онд Хонконгийн хөрөнгийн биржээс зохион байгуулж байсан санал асуулга, түүний дүгнэлттэй холбоотой бичиг баримтууд болон тус биржийн Үнэдсэн бүртгэлийн дүрмийн 18 дугаар бүлгийн агуулгыг сайтар судлахыг зөвлөж байна.

---oOo---

## Хавсралт 1

Иймд нэвтрүүлэхээр судлагдаж буй ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодексын хэрэглээний цар хүрээг ойлгомжтой байлгах хүрээнд уг үнэлгээг байгалийн баялаг, ашигт малтмалын баялаг, ашигт малтмалын орд, ашигт малтмалын нөөц гэх мэт ойлголтуудыг хэрхэн ашиглахыг хуульд нэгэнт тодорхойлоод байгаа дээр дурдсан тодорхойлолтуудтай уялдуулан авч үзэхийг зөвлөж байна.

<b>“Ашигт малтмал”-тай холбоотой тодорхойлолтууд</b>	
АМТХ-ийн 4.1.1	“ <b>ашигт малтмал</b> ” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсч бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлалыг
ТТАМТХ-ийн 4.1.1	“ <b>түгээмэл тархацтай ашигт малтмал</b> ” гэж зам, барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий элс, хайрга, тоосгоны шавар, хүрмэн, боржин, дайрганы зориулалттай барилгын чулууны хуримтлалыг;



ГТТХ-ийн 4.1.1	“ <b>газрын тос</b> ” гэж “газрын хэвлийд болон агаарын хэвийн даралт, хэмд хатуу, шингэн, хийн төлөвт орших нүүрс-устөрөгчийн нэгдэл /түүхий тос, байгалийн хий/-ийг”
ГТТХ-ийн 4.1.2	“ <b>түүхий тос</b> ” гэж газрын хэвлийд болон агаарын хэвийн даралт, хэмд шингэн төлөвт орших нүүрс-устөрөгчийн нэгдлийг,
ГТТХ-ийн 4.1.3	“ <b>байгалийн хий</b> ” гэж “газрын хэвлийд болон агаарын хэвийн даралт, хэмд хийн төлөвт дангаар орших нүүрс-устөрөгчийн нэгдлийг”,
ГТТХ-ийн 4.1.4	“ <b>уламжлалт бус газрын тос</b> ” гэж “байгалийн битум, шатдаг занар, тослог элс, хийтэй элс, хийтэй занар, нүүрсний давхаргын метан хийг”,
ГТТХ-ийн 4.1.5	“ <b>нүүрсний давхаргын метан хий</b> ” гэж нүүрсжих явцад нүүрсэнд хуримтлагдсан хийг
ЦЭТХ-ийн 3.1.4	“ <b>цацраг идэвхт ашигт малтмал</b> ” гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.2-т заасан уран болон торийн бүлийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс баялгийн хуримтлалыг;
<b>Баялаг, орд, нөөцтэй холбоотой тодорхойлолтууд</b>	
АМТХ-ийн 4.1.24	“ <b>ашигт малтмалын баялаг</b> ” гэж геологийн зураглал, сэдэвчилсэн судалгаа, эрэл, хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн, эдийн засгийн ач холбогдол нь нарийвчлан үнэлэгдээгүй эрдсийн хуримтлалын хэсгийг
АМТХ-ийн 4.1.9	“ <b>ашигт малтмалын орд</b> ” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтож чанар, нөөц нь тодорхойлогдсон, үйлдвэрийн аргаар олборлоход эдийн засгийн хувьд ашигтай эрдсийн хуримтлалыг
АМТХ-ийн 4.1.25	“ <b>ашигт малтмалын ордын нөөц</b> ” гэж хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон, үйлдвэрийн аргаар олборлох боломжтой, эдийн засгийн үр ашигтай, баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдсон ашигт малтмалын баялгийн хэсгийг
АМТХ-ийн 4.1.12	“ <b>стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд</b> ” гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг
ТТАМТХ-ийн 4.1.4	“ <b>түгээмэл тархацтай ашигт малтмалын орд</b> ” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд бүрэлдэн тогтож чанар, нөөц нь тодорхойлогдсон, үйлдвэрийн аргаар олборлоход эдийн засгийн хувьд ашигтай эрдсийн хуримтлалыг;
АМТХ-ийн 4.1.10	“ <b>ашигт малтмалын үндсэн орд</b> ” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд бүрэлдэн тогтож анхлан үүссэн чулуулагтайгаа нэг орон зайд байрлаж байгаа эрдсийн хуримтлалыг
АМТХ-ийн 4.1.11	“ <b>ашигт малтмалын шороон орд</b> ” гэж анхлан үүссэн чулуулаг, орон зайнаасаа өгөршил, элэгдэл, механик үйл явцын дүнд сарнин салж, дахин хуримтлагдаж улмаар үе, давхарга байдалтай байгаа эрдсийн хуримтлалыг
ГТТХ-ийн 4.1.23.“	“ <b>газрын тосны орд</b> ” гэж геологийн хувьсал, өөрчлөлтөөр газрын хэвлийд үүссэн, чанар, нөөц нь тогтоогдсон газрын тосны хуримтлал бүхий бүтэц, давхарга зүйн онцлогоор төстэй нэг буюу хэд хэдэн хураагуурыг;
<b>Эрэл, хайгуул, ашиглалттай холбоотой тодорхойлолтууд</b>	

АМТХ-ийн 4.1.3	“ <b>тойм судалгаа</b> ” гэж ашигт малтмал байгаа эсэхийг тогтоох зорилгоор газрын хэвлийг хөндөхгүйгээр чулуулгийн сорьц, дээж авах, геологи, ашигт малтмалын анхдагч мэдээллийг ашиглах, агаарын зураг авах аргаар геологийн судалгаа хийхийг
АМТХ-ийн 4.1.5	“ <b>ашигт малтмал эрэх</b> ” гэж ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд эрдсийн хуримтлал байгаа эсэхийг тогтоох зорилгоор хийгдэж байгаа геологийн судалгааны ажлыг,
ГТТХ-ийн 4.1.7.	“ <b>эрэл</b> ” гэж тодорхой нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хэтийн төлөвийг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизикийн тойм судалгааны ажлыг;
АМТХ-ийн 4.1.6	“ <b>ашигт малтмал хайх</b> ” гэж эрдсийн хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг
ТТАМТХ-ийн 4.1.2	“ <b>түгээмэл тархацтай ашигт малтмал хайх</b> ” гэж түгээмэл тархацтай ашигт малтмалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг;
ГТТХ-ийн 4.1.8, 4.1.9	“ <b>хайгуул</b> ” гэж газрын тосны орд нээж, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизик, өрөмдлөг, олборлолтын туршилтын ажлыг;  “ <b>үнэлгээ</b> ” гэж нээлтийн цооногоор илрүүлсэн хуримтлал нь үр ашигтай нээлт болох эсэхийг тодорхойлох зорилгоор хийх ажлыг;
АМТХ-ийн 4.1.7	“ <b>ашигт малтмал ашиглах</b> ” гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг
ТТАМТХ-ийн 4.1.3.	“ <b>түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах</b> ” гэж түгээмэл тархацтай ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу газрын гадаргуу, хэвлийгээс ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг;
ГТТХ-ийн 4.1.16.	“ <b>ашиглалт</b> ” гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны орд ашиглалтын бүтээн байгуулалт, олборлолтын үйл ажиллагааг;
ЦЭТХ-ийн 3.1.2	“ <b>цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах</b> ” гэж цөмийн энергийг цөмийн зэвсгээс бусад салбарт ашиглахыг